

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА  
2024 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр, Пүрэв гараг**

**Хуралдааны тэмдэглэлийн агуулга**

**Хуралдааны товч тэмдэглэл:** 1-3

**Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:** 4-26

---

|                                                                                                                                                                                                                                              |       |
|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------|
| 1.Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нарын 3 гишүүн 2024.04.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/                            | 4-12  |
| 2.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нарын 3 гишүүн 2024.04.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/ | 12-18 |
| 3.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нарын 3 гишүүн 2024.04.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/           | 18-26 |

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы  
Төрийн байгуулалтын байнгын хорооны  
04 дүгээр сарын 11-ний өдөр /Пүрэв гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Н.Энхболд ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 32 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

Томилолттой: С.Амарсайхан, Ж.Батсуурь, С.Бямбацогт, Ц.Мөнхцэцэг;

Чөлөөтэй: Ё.Баатарбилэг, Л.Оюун-Эрдэнэ;

Эмнэлгийн чөлөөтэй: Т.Доржханд, Ц.Мөнх-Оргил.

**Нэг.Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нарын 3 гишүүн 2024.04.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, дэд дарга Ц.Батбаатар, Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Анар-Эрдэнэ, Б.Баярмаа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, мөн хэлтсийн референт А.Наранцэцэг, Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх Ж.Бямбадулам, Ж.Сайнхишиг нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд танилцуулав.

Төслийн үзэл баримтлалын талаар Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалмаа, М.Оюунчимэг, Г.Ганболд нарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд хариулж, тайлбар хийв.

**Н.Энхболд:** Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 3

Бүгд: 11

72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалмаа Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 11 цаг 06 минутад хэлэлцэж дуусав.

**Хоёр.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нарын 3 гишүүн 2024.04.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын дэд дарга Ц.Батбаатар, Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Анар-Эрдэнэ, Б.Баярмаа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, мөн хэлтсийн референт А.Наранцэцэг, Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх Ж.Бямбадулам, Ж.Сайнхишиг нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд танилцуулав.

Төслийн үзэл баримтлалын талаар Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалмаа, Ц.Туваан нарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд хариулж, тайлбар хийв.

**Н.Энхболд:** Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

|             |    |
|-------------|----|
| Зөвшөөрсөн: | 7  |
| Татгалзсан: | 4  |
| Бүгд:       | 11 |

63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 11 цаг 28 минутад хэлэлцэж дуусав.*

**Гурав. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нарын 3 гишүүн 2024.04.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Анар-Эрдэнэ, Б.Баярмаа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх Ж.Бямбадулам, Ж.Сайнхишиг, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн зөвлөх С.Доржханд нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд танилцуулав.

Төслийн үзэл баримтлалын талаар Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл, Г.Ганболд нарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат нар хариулж, тайлбар хийв.

**Н.Энхболд:** Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн үзэл

баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 4  
Бүгд: 11  
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболд Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 11 цаг 54 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 1 цаг 23 минут үргэлжилж, ирвэл зохих 19 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 57.9 хувийн ирцтэйгээр 11 цаг 55 минутад өндөрлөв.*

Тэмдэглэлтэй танилцсан:  
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Н.ЭНХБОЛД

Тэмдэглэл хөтөлсөн:  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр,  
Пүрэв гараг  
Төрийн ордон “Үндсэн хууль” танхим  
10 цаг 32 минут.

### ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Н.Энхболд:** Байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэнд хүргэе. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн учраас хоёр мянга, Оюунчимэг, 2024 оны 4 сарын 10-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. Байнгын хорооны хуралдаанд хэлэлцэх асуудлыг танилцуулъя. 19 гишүүнээс 10 ирсэн байна. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн, хэлэлцэх асуудлуудаа танилцуулъя. Хэлэлцэх асуудлуудаа танилцуулъя. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд байгаа. Их Хурлын гишүүн Нямаагийн Энхболд нарын 3 гишүүн 4 сарын 5-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэхийг ярина. 2 дугаарт Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл хамт өргөн мэдүүлсэн хуулиуд байгаа, мөн өдөр Их хурлын гишүүн Энхболд нарын 3 гишүүн өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэхийг нь ярина. 3 дугаарт Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд 24 оны 4 сарын 5-ны өдөр Энхболд нарын 3 гишүүн өргөн мэдүүлсэн хэлэлцэх эсэх асуудлуудыг ярина. Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Хэлэлцэх асуудалдаа оръё. Хэлэлцэх асуудалдаа оръё, юу хаана байна вэ, миний танилцуулга хаана байна вэ?

**Нэг.Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл**

**болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нарын 3 гишүүн 2024.04.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцүүлгийг явуулна. Хууль санаачлагчийн хувьд би танилцуулгыг нь хийчихье.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Их Хурлын гишүүн Энхболд, Мөнхбаатар, Тэмүүлэн нар 2024 оны 4 сарын 5-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. Их Хурлаас 23 оны 5 сарын 31-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуулийн хуульд оруулсан өөрчлөлтөөр Үндсэн хуулийн 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг Улсын Их Хурал нэг танхимтай, 126 гишүүнтэй байна, Улсын Их Хурлын 78 гишүүнийг олныг төлөөлөх, 48 гишүүнийг хувь тэнцүүлэн төлөөлөх аргаар сонгоно гэж өөрчлөн найруулсан. Мөн Их Хурлын 23 оны 44 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарийн 6-д Монгол Улсын Их Хурлын тухай хуулийг Улсын Их Хурлын 24 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд дээрх өөрчлөлттэй нийцүүлэхээр заасан байгаа. Мөн Их Хурлын тухай хуулийг хэрэгжүүлэх явцад зарим зохицуулалтыг тодорхой болгох, нарийвчлах, нэр, томъёог нь Үндсэн хууль, бусад хуульд нийцүүлэх, жигдлэх практик хэрэгцээ шаардлага байна гэж үзсэн. Энэ үндэслэл шаардлагуудыг харгалзаж үзээд хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулсан болно.

Хуулийн төслөөр Монгол Улсын Их Хурлын бүрэн эрх түүний зохион байгуулалтын бүтэц, бүрэлдэхүүн, Их

Хурлын гишүүний бүрэн эрх, халдашгүй байдал, түүний баталгаа, Их Хурлын гишүүн үйл ажиллагааны журмыг тогтоохтой холбогдсон харилцаануудыг зохицуулсан төсөл нийтдээ 8 бүлэг, 53 зүйлтэй. Хуулийн төсөлд дараах зарчмын шинжтэй зохицуулалтыг шинээр буюу шинэчлэн боловсруулахаар тусгасан байгаа. Энд 1 дүгээрт Улсын Их Хурлын зохион байгуулалтын бүтцийг боловсронгуй болгох хүрээнд Байнгын болон бусад хороодын талаар бүлэг байгаа. Их Хурлын үндсэн бүтцийг тодорхойлохдоо бүрэн эрхээ шинээр эхлүүлж байгаа Их Хурал бодлогоо тодорхойлж байх чиг хандлагыг харгалзаад Их Хуралд зайлиггүй байх бүтцийг оновчтой, давхардалгүй байх зарчимд нийцүүлэн тодорхойлсон. Төсөлд бид нар Их Хурал 11 Байнгын хороотой байхаар, тэгээд дотроо зарим үүрэг хариуцах чиглэлийн хувьд шилжүүлж болох бодлогуудыг харгалзан үзээд Аж үйлдвэржилтийн бодлогын, Аюулгүй байдал, гадаад бодлогын, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын, Ёс зүй, дэгийн, Инновац, цахим бодлогын, Нийгмийн бодлогын, Төрийн байгуулалтын, Төсвийн, Хууль зүйн, Эдийн засгийн гэсэн 11 Байнгын хороотой байхаар. 1 Байнгын хороо 25 хүртэл гишүүнтэй байхаар хуучнаас бүрэлдэхүүний тоог нэмэгдүүлж, 1 гишүүн 2-оос илүүгүй Байнгын хороонд харьяалагдахаар тусгасан байгаа.

Энэ Байнгын хорооны гишүүнчлэл тодорхой хязгаарлалтуудыг зохицуулалтуудыг тогтоохоор бас оруулсан. Тухайлбал, Их Хурлын дарга, Ерөнхий сайд, ЗГ-ын гишүүний албан үүргийг хавсран гүйцэтгэж байгаа гишүүн зөвхөн нэг Байнгын хороонд харьяалагдахаар, ЗГ-ын гишүүний албан үүргийг хавсран гүйцэтгэж байгаа гишүүний хувьд эрх асуудал нь хамаарах салбарын Байнгын хороонд харьяалагдахгүй байхаар, 1 Байнгын хороонд ЗГ-ын гишүүний албан үүрэг гүйцэтгэж байгаа гишүүн 2-оос илүүгүй байхаар, Ерөнхий сайд, ЗГ-ын гишүүний

албан үүргийг хавсран гүйцэтгэж байгаа гишүүнд Байнгын, дэд, хянан шалгах түр хорооны даргаар ажиллахгүй байх зарчмуудыг төсөлд тусгасан.

Байнгын хорооны харьяанд түүний эрхлэх асуудлын тодорхой хэсгийг дагнан хариуцах үүрэг бүхий дэд бүхий дэд хороонууд байдаг. Шинэ төслөөр бас ийм дэд хороотой байхаар, дэд хорооны гол үүрэг нь хяналт шалгалтын ажил байхаар төсөлд тусгасан. Тусгай хяналтын, Төсвийн зарлагын хяналтын, Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын, Хүний эрхийн, Тогтвортой хөгжлийн дэд хороог хуулиар байгуулахаар бусад дэд хороог Байнгын хорооны саналыг үндэслээд Улсын Их Хурал нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж шийдэж байхаар тусгасан.

Хянан шалгах түр хорооны зохицуулалтыг боловсронгуй болгох хүрээнд түр хороог байгуулах хугацаа, байгуулж болохгүй нөхцөл, хорооны төсөв зэрэг харилцааг илүү тодруулж, шинээр тусгасан. Тухайлбал, Хянан шалгах түр хороог дараах тохиолдолд байгуулахгүй байхаар санал оруулж байгаа. Үүнд Их Хурлын нэгэн бүрэн эрхийн хугацаа дуусахад 6 сараас бага хугацаа үлдсэн болбол, мөн тухайн асуудлаар Хянан шалгах түр хороо ажиллаж байгаа болбол, яллах дүгнэлт үйлдээд шүүхэд шилжүүлсэн эрүүгийн хэрэгтэй холбоотой асуудлаар, татан буугдсанаасаа буугдсанд тооцсоноос хойш нэг жилийн хугацаа өнгөрөөгүй байгаа бол түр хороодыг байгуулж болохгүй байхаар тусгасан.

Нам, эвслийн бүлгийн бүлгүүдийн талаар Үндсэн хуулийн шинэчлэлээр гишүүдийн тоо нэмснийг харгалзаад бүлгээ, бүлэгт 12 ба түүнээс дээш гишүүн байхаар болбол шинэ бүлэг байгуулж болохоор зохицуулж тусгаж байна. Одоо бол 8 байгаа. Энэ бол Их Хурлын нийт гишүүдийн 10 орчим хувьтай тэнцүү. Шинэ хуулиараа ч гэсэн 126 гишүүнээс тооцоод 12 байхад



тохиромжтой юм гэсэн ийм санаагаар тусгасан байгаа. Нам, эвслийн бүлэг байгуулах, тарах, гишүүн өөр бүлэгт нэгдэх, гарах, ЗГ байгуулах, бүлэг байгуулах зэрэг харилцааг нарийвчилж зохицуулсан. Үүгээрээ хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага тогтвортой бүтээмжтэй ажиллах нөхцөлийг харгалзаж үзсэн гэж бодож байна.

Улсын Их Хуралд суудалтай нам, эвслийн сахилга батыг сайжруулах, хариуцлагыг дээшлүүлэх, хууль тогтоох ажиллагааны чанар үр нөлөөг сайжруулах зорилгоор нам, эвслийн бүлэг хууль тогтоомжийн төсөлд санал дүгнэлт заавал гаргах, нэгдсэн хуралдаанд нам, эвслийн бүлгийн байр суурийг тодорхой тооны гишүүд төлөөлөн илэрхийлж байх, нам, эвслийн бүлгийн саналаар хууль тогтоомжийн үзэл баримтлалын хүрээнд мэтгэлцээн явуулах зэрэг шинэ зохицуулалтуудыг тусгасан. Их Хурлын бие даасан байдлын баталгааг дээшлүүлэх хүрээнд Их Хурлын зохион байгуулалт үйл ажиллагааны журмыг Үндсэн хууль, Их Хурлын тухай хууль, Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хууль, Их Хурлын хяналт, шалгалтын тухай хууль, Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиас бусад хуулиар зохицуулахыг хориглосон энэ заалтыг шинээр тусгасан. Ингэснээр бол Монгол Улсын төрийн эрх барих дээд байгууллага Улсын Их Хурлын биеэ даасан байдлын хууль зүйн баталгаа нь дээшилнэ ийм нөхцөл бүрдэнэ гэж үзэж байгаа.

Гишүүдийн халдашгүй байдал бүрэн эрхийн баталгаатай холбоотой зохицуулалтын хүрээнд Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдал бүрэн эрхийг түдгэлзүүлэх эсэх асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх үндэслэл журмыг түрүүчийнхээс нарийвчилж зохицуулсан. 23 онд баталсан Их Хурлын Үндсэн хуульд оруулсан, Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтөөр Их Хурлын нэг гишүүнд ноогдох зардлын хэмжээг

нэмэгдүүлэхгүй байх зарчмыг баримтлаад гишүүний зөвлөх, туслах, бие төлөөлөгч, туслахын орон тоо, гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд зайлиггүй шаардлагатай бусад зардал хангамжийг тогтоох хууль зүйн үндсийг энэ хуулийн төсөлд тусгасан байгаа. Их Хурлын үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг дээшлүүлэх хүрээнд үйл ажиллагааны талаарх нээлттэй мэдээллийг хийх албан тушаалтнуудыг хуулийн төсөлд тодорхойлж өгсөн. Тухайлбал, Их Хурлын дарга, гишүүн, нам, эвслийн бүлгийг бүлгийг төлөөлж дарга, дэд дарга, Байнгын, дэд, хянан шалгах түр хорооны дарга, Тамгын газрын холбогдох албан тушаалтан мэдээлэл хийж байхаар зохицууллаа.

Түүнчлэн Улсын Их Хурал чуулганы хуралдааныг шууд нэвтрүүлэх үйл ажиллагаа батлагдсан хууль тогтоомжийг сурталчлах телевиз, радиогийн тусгай сувагтай байж болохоор төсөлд тусгасан. Их Хурлын үйл ажиллагааны журмыг боловсронгуй болгох хүрээнд ОУПХ-ны гишүүн орнуудын хүрээнд нийтлэг жишиг болж мөрдөгддөг хуулийн төсөл хэлэлцэхэд мэтгэлцээн явуулах зохицуулалтыг боловсронгуй болгож оруулсан. Нам, эвслийн бүлгээс төслийн үзэл баримтлалын хүрээнд мэтгэлцээн явуулах шаардлагатай гэж санал, дүгнэлт гаргасан бол чуулганы нэгдсэн хуралдаанаараа хууль, Их Хурлын бусад шийдвэрийн төслийг хэлэлцэх үед хэлэлцэх эсэх шатад, хэлэлцэх эсэх шатад шүү мэтгэлцээн явуулахаар төсөлд тусгасан байгаа.

Их Хурлын Тамгын газар, Их Хурлын гишүүний зөвлөх, туслах, бие төлөөлөгч, туслах, Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлгийн ажлын албаны чиг үүрэг, эрхлэх ажил, ажилтны эрх зүйн байдлыг хуулийн төсөлд өмнөхөөс илүү нарийвчилж тусгасан. Их Хурлын гишүүний зөвлөх, туслах нь гишүүнд бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд хэрэгжүүлэхэд нь мэргэжил, арга зүй, техник, зохион байгуулалтын туслалцаа

дэмжлэг үзүүлэх үүрэг гүйцэтгэх зохицуулалтуудыг тусгасан байгаа.

Энэ дээрх хуулиудтай уялдуулаад Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хамт холбогдох бусад хуулийн төслүүдийг боловсруулж өргөн мэдүүлчхээд байгаа. Ингээд Байнгын хорооны хуралдаанаар төслийг хэлэлцэх эсэх асуудлыг шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Хууль санаачлагчийн илтгэлтэй холбогдуулаад асуух гишүүн байна уу? 4 гишүүнээр Сарангэрэл, Жаргалмаа, Оюунчимэг, Ганболд, Пүрэвдорж. Сарангэрэл гишүүн.

**Д.Сарангэрэл:** Баярлалаа. Манай Байнгын хороонд бол бас олон чухал хуулийн төслүүд орж ирж байна л даа. Тэгээд энэ дотроос сая Байнгын хорооны дарга маань бүх хуулиудынхаа танилцуулгыг нэгтгээд хийчихсэн учраас би Хяналт шалгалтын тухай хуультай холбоотой асуулт тавьж болох уу?

**Н.Энхболд:** Тусдаа.

**Д.Сарангэрэл:** За, тэгвэл би дараа нь больё. Баярлалаа.

**Н.Энхболд:** Жаргалмаа гишүүн, Жаргалмаа гишүүний микрофоныг өгье.

**Б.Жаргалмаа:** Баярлалаа. Би зүгээр хуулийн заалтыг мэдээж хэрэг дэмжээд явна, хуулийг дэмжээд явна хуулийн төслийг. Нэг хэд хэдэн зүйлийг тодруулах гэсэн юм. Энэ гишүүний бүрэн эрх гэж байгаа. Гишүүний бүрэн эрх гэхээр олон нийт ч гэсэн их анхаарал тавьдаг. Зүгээр яг өнөөдөр болж байгаа үйл явдалтай гэдэг юм уу, өнөөдөр өрнөж байгаа энэ нөхцөл байдалтай холбогдуулан гишүүний бүрэн эрх дээр 8.1.4 дээр нэг зүйл тодруулах гэсэн юм. Нэгдсэн хуралдаанд болон өөрийн харьяалагддаг Байнгын, дэд, хянан шалгах түр хорооны хуралдаанд таслах эрхтэйгээр оролцох гэсэн нэг ийм заалт

яваад байгаа юм. Яг өнөөдөр зүгээр сонгуулийн жилийн хугацаанд ч гэдэг юм уу, Байнгын хороодын ирц бүрдэхгүй байх. Түүнээс шалтгаалан хүлээгдэх, ирц хүлээсэн төрийн албан хаагчид гэдэг юм уу, хуулийн төсөл нь хэлэлцэгдэж байгаа тухайн салбарын яам, агентлагийн албан тушаалтнууд өдөржингөө л Төрийн ордонд суух юм л даа. Ирц хүрэхгүй байгаагаас шалтгаалан тэгээд. Энэ таслах эрхтэй оролцох гэдэг үгийг л би энийг тайлбарлаж өгөөч гэж даргаас хүсэж байна. Өөрөөр хэлэх юм болбол бид зөвхөн гишүүдийн эрх гэдгээрээ тойрогт ажиллах тэр боломжийг нь олгож байгаа гэдэг байдлаараа яг өнөөдрийн байдлаар бол Байнгын хорооны ирц хүрэлцэхгүй хэдэн өдөр л үргэлжиллээ. Энэ долоо хоногийн хувьд лав, 3 дахь өдөр болон 2 дахь, 3 дахь өдөр бол Байнгын хороод хуралдаж чадсангүй.

Тэгээд энэ нь өөрөө энэ таслах эрхтэй оролцох гэдэг энэ үгнээс чинь шалтгаалаад гишүүд хуралдаа суухгүй байх, тойрогт ажиллаж байна гэдэг шалтгааны улмаас ирц бүрдэхгүй төрийн ажил гацсан ийм байдалтай. Бид ирц бүрдэхгүйгээс шалтгаалан яамд, агентлагийн дарга нар нь энд асуудал оруулах гээд хүлээгээд суугаад байдаг. Түүнийг хүлээж байгаа тийм ээ иргэн ч байгаа, яамны ажил ч гэсэн гацсан хүлээсэн. Нөгөө төрийн данхар байдал гэдэг юм уу, төр хүнд сурталтай гэдэг энэ нэр томъёо чинь эндээс гараад байдаг юм шүү дээ. Энэ заалтыг тодруулъя.

Нөгөө талаар хуульд өөрөөр заагаагүй бол хууль тогтоомжийн төслийн талаар зарчмын зөрүүтэй саналын томъёоллоо холбогдох Байнгын хороонд ажлын 2-оос доошгүй өдрийн өмнө хүргүүлэх гэдэг 8.1.9 дэх заалт. Бид нар хууль хэлэлцээд зүгээр төсөв хэлэлцэж байхад чинь энэ заалтыг ингээд өөрчилчихье, өөрчилчихье гээд л, яг хэлэлцэж байх явцадаа л бид нар зарчмын зөрүүтэй саналын томъёоллоо оруулаад өгөөд байдаг шүү дээ. Тийм ээ. Тэгэхээр энийг өөрчилж байна гэж



ойлгох уу? Хэрвээ хэрэгжихгүй бол ийм заалт оруулах шаардлага байна уу? Яг хэлэлцэж байх явцдаа л оролцож бид нар саналаа өгчихдөг шүү дээ тийм ээ.

Тэгээд гишүүн бүрэлдэхүүнд нь ороогүй Байнгын, дэд хорооны хурлаар нь таслах эрхгүйгээр оролцож болно гээд л. Энийг бол хүлээн зөвшөөрч байгаа. Түрүүний таслах эрхтэй оролцох гэдэг энэ томьёоллын хэлж өгөөч. Таслах эрхтэй юм болбол заавал тийм ээ тэр Байнгын хороонд оролцох ямар ч эрхтэй байдаг юм тэгээд. Энэ дээр нэг тайлбар өгөөч.

**Н.Энхболд:** Тийм, үгүй ээ таслах эрх болбол жишээ нь Улсын Их Хурлын гишүүн нэгдсэн чуулганы хуралдаанд харьяа Байнгын хорооныхоо хуралдаанд харьяа эсхүл харьяа дэд хороо, Хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүнд оролцохдоо дэмжсэн, дэмжээгүй санал өгч болно гэдгийг л хэлж байгаа юм. Таслах эрх гэдэг бол зөвхөн санал өгөх тухай асуудал. Түүнээс бусдаар оролцож болно, ирцэд нь орохгүй ч гэсэн аль ч Байнгын хорооны хуралдаанд ороод саналаа хэлж болно, асуулт асууж болно ийм зохицуулалттай. Тэгээд таслах эрхийн хувьд ерөөсөө одоо байгаа юм нь яг хэвээрээ байгаа ойлгомжтой асуудал. Энэ санал өгөх, өгөхгүйн тухай л асуудал байгаа юм.

2-оос доошгүй хоногийн өмнө саналаа бичгээр өгч байна гэдэг бол 2 үндсэн нөхцөл байдлыг харгалзаж үзээд үүгээр оруулж байгаа юм байна лээ. Одоо бол үнэн. Ингээд байж байгаад л Байнгын хороон дээр гэнэт гүйж орж ирээд л эсхүл чуулган дээр гэнэт орж ирээд л голдуу Байнгын хороон дээр гардаг, чуулган дээр болбол гэнэт тэгж санал хураалгах боломж байхгүй. Ер нь болбол Улсын Их Хурлын гишүүн тэр хэлэлцэж байгаа асуудлыг сайн судалж, өөрийн болгож, тодруулах ёстой зүйлүүдээ аваад, тэгээд өөрийнхөө байр суурийг илэрхийлэхийн тулд бас үндэслэлтэй судалгаатай, тооцоотой, аргумент сайтай ийм саналууд

дэвшүүлж байх хэрэгтэй юм байгаа юм. Зүгээр би гишүүдийг бүгдээрээ тэгдэг гэж хэлэхгүй. Тэгэхдээ манайд болбол жишээ нь хуралдааны явцад гишүүн гэнэтхэн орж ирээд зарим тохиолдолд ямар асуудал хэлэлцэж байна гэснээ санал гаргадаг хүртэл тохиолдол бий. Энэ бол өөрөө бас их зохимжгүй зүйл байгаа юм. Төлөвшчихсөн, улс төрийн соёл нь төлөвшчихсөн Их Хурал нь олон арван жил, олон зуун жил ажиллачихсан бусад парламентуудын жишиг юмнаас харахад болбол зарим газар бүр заавал бичгээр хүртэл саналаа өгч байдаг ийм зүйлүүд байдаг. Тэгэхээр бид энэ төслийг оруулахдаа яг энэ байдлыг харгалзаад гишүүн ярилцаж байгаа хууль тогтоомжийн төслийг их сайн судлаасай, байр сууриа илэрхийлэхдээ надад ийм, ийм учраас энэ бол буруу байна, ийм, ийм учраас би ийм шинэ зарчмын зөрүүтэй санал гаргана гэдгээ их нарийвчилж, үндэслэлтэй судалгаатай тусгаж байх энэ 1 дүгээрт ийм шаардлага байна. 2 дугаарт ийм байдал одоогийн байгаа байдлыг бас өөрчлөх ийм асуудал байгаа. Тийм учраас үүнийг гишүүдийг илүү асуудалдаа хариуцлагатай, зөв хандаж байх үүднээс ийм зохицуулалт оруулж байгаа юм.

Яах вэ дараагийн Их Хурал өөрөө дэгээ боловсруулаад бас зохицуулаад явах боломж бий. Тэгэхдээ тэгэхгүй ээ, бид нар зүгээр дуртай үедээ орж ирээд л дуртай саналаа өгөөд л, дуртай юмаа яриад явж байна гэдэг ийм дэг гаргаад, мөрдөөд явбал тэр Их Хурлын асуудал. Тэгэхдээ тийм юм бол туйлын зохимжгүй юм байдаг байна гэдэг нь тухайлбал манай Улсын Их Хурлын 30-аад жилийн түүх практикаас харагдчихсан ийм зүйл байхгүй юу. Тэгэхээр тэр аль болохоор гишүүдээ хариуцлагатай, тооцоотой, судалгаатай, юмаа үндэслэлтэй яг хэлэлцсэн асуудалтайгаа уялдуулж ярьж байх нөхцөлийг л бүрдүүлэх гэж ийм заалт оруулсан юм. Тэгээд хэлэлцэх явцдаа янз бүрийн саналууд гаргаж болно. Тийм. Жаргалмаа гишүүн тодруулья.

**Б.Жаргалмаа:** Яг таны сая сүүлд хэлсэн хариуцлагатай байх, хариуцлагажуулах гэдэг үүрэг болбол бид нарын өнөөдрийн батлах гэж байгаа энэ хууль нь шинэ Үндсэн хуулиараа бүрдэх 126 гишүүнтэй парламентын хувьд бас маш нарийн хэлэгдэх ёстой болов уу л гэж бодож байна. Яагаад гэвэл 126 болох тусмаа магадгүй тэр хариуцлагатай байдал нь алдагдах, бид нар уг нь олон намын үзэл баримтлалыг бий болгох тийм ээ, олон төлөөллийн үгийг сонсохын тулд Үндсэн хуульдаа өөрчлөлт оруулсан байгаа. Тэгэхээр ер нь бол бид нар Дэгийн тухай хуульдаа тодорхой хэмжээний хариуцлагын асуудлыг зааж өгөхгүй болбол бид 76 байхдаа хурлаа бүрдүүлж чадахгүй байгаа ийм нөхцөл байдалд 126 болох тусам нөгөө хариуцлагагүйн асуудал улам бүүр задгайрах вий гэдэг үүднээсээ бид энэ таслах эрхтэй оролцох гэдэг үгэн дээр бас тодорхой анхаарч ажиллаач гэдэг л хүсэлтийг тавих гэсэн юм. Асуудал тийм ээ хэлэлцэгдэхгүй, төрийн ажил гацсан энэ байдал бол Их Хурал дээр бид нар бүрэн халж, энэ хариуцлагатай байх, хүлээсэн үүргээ биелүүлдэг байх, гишүүдээс нь хариуцлага нэхдэг байх энэ байдлыг л.../минут дуусав/

**Н.Энхболд:** Баярлалаа. Санал байна. Тийм ээ. Оюунчимэг гишүүн асууя. Оюунчимэг гишүүний микрофон.

**М.Оюунчимэг:** Бүлэг дээрх хуулийн төслийг танилцуулж байхад Байнгын хороо 9 байсан, өнөөдөр буцаад нөгөө 11 Байнгын хороотой болоод Инновац, Үйлдвэржилтийн байнгын хороог хэвээр нь бас үлдээж байна тийм ээ. Уг нь энэ Байнгын хороо гэдэг бол тухайн улс орнуудын парламентын бол одоо жишээ нь манай улс парламентын засаглалтай орон. Тэгээд ард түмэн парламент хоёрын гүүр нь бол бид нар болдог. Тэгээд иргэд парламентдаа хандаад ийм тулгамдсан асуудлууд байна гээд 900-аас дээш хүн гарын үсгээ хүртэл зураад асуудал шийддэг байсан. Өмнө

жишээ нь Өргөдлийн байнгын хороо байхад бид нар Туул голын эрэг орчим бүх төрлийн хууль зөрчөөд хашаа хайс хатгачихсан, орон сууц барьж байгаа энэ тэрийг Өргөдлийн байнгын хороонд 1000-аад хүн гарын үсэгтэй ирээд л, бид нар энэ асуудлуудыг зогсоож нэг талаасаа байгаль, далай усаа ч хамгаалж байна. Нөгөө талаасаа хот төлөвлөлт дээр ч гэсэн ингээд бас тодорхой арга хэмжээнүүд аваад яваад байдаг байсан.

Тэгээд сая энэ 20 оноос хойш нөгөө энэ жишээ нь Өргөдлийн байнгын хороог татан буулгаснаас болоод нөгөө тухайн Байнгын хороод нь иргэдээс ирсэн өргөдөл гомдлыг хариуцна гэхихсэн хэр нь сая лав энэ 4 жилд энэ бол орхигдсон. Эргээд сүүлдээ хүмүүс нөгөө нэг хуучин Өргөдлийн байнгын хорооны даргаар би ажиллаж байсан болохоор үгүй ээ бид нар өргөдөл өгсөн юм, тэгээд энэ өргөдлийн хариу байхгүй, энүүгээр авах арга хэмжээ алга байна гээд нөгөө ард түмэн парламент хоёрын гүүр болдог асуудал орхигдсон. D-parliament дээр бол саналууд авдаг. Гэхдээ тэр бол голчлон хуулийн төсөлд өгдөг санал байна. Тэгэхээр бид нар энэ зүйлүүд дээр цаашидаа анхаармаар байна. Ялангуяа парламентын тогтолцоо, одоо ингээд бид нар чинь мажоритар байсан, одоо ингээд пропорциональ гээд том болж байна. Гишүүдийн тоо 126 болж байна. Монголын нийгэмд тулгарч байгаа асуудал их байна. Тэгээд иргэд парламент 2 юм уу, төр засаг бие биеэсээ холдох ийм зүйл хүртэл бас бий болох магадлалыг жишээ нь социал гүйцэтгэж байна шүү дээ. Тэгэхээр бид нар энд жишээ нь байгаль орчин, хүнс, хөдөө, Байгаль орчин, аялал жуулчлал, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо гээд маш том байнгын хороотой. Энэ байгаль орчны асуудал, аялал жуулчлал, хөдөө аж ахуйн асуудал гээд том Байнгын хороо байгаа хэр нь яг одоогийн байдлаар энэ Байнгын хороо хөдөө аж ахуйг л голлож байна. Байгаль орчин дээр нэг хааяа хуулийн төсөл орж ирдэг, аялал

жуулчлал нь орхигдчихсон байгаад байдаг.

Гэтэл манай өнөөдөр манай Монгол улсад хамгийн чухал асуудал юу байгаад байна вэ гэхээр энэ агаар, хөрсний бохирдол 98 хувь, бараг 100 хувьтай болоод энийг дагасан нөгөө гепатит вирусүүд, элдэв халдварт өвчин, хавдар гээд Монголын хүн ам энүүгээр бол бараг өвчлөл нь дэлхийд ингээд толгой цохиж байна шүү дээ. Тэгэхээр байгаль орчин, агаар, хөрсний бохирдлыг бууруулах Байнгын хороо ч гэдэг юм уу, яг тухайн үед энэ улс орны өмнө, иргэдийн өмнө тулгарч байгаа чухал асуудлыг тухайн Байнгын хороо нь хэлэлцээд шийдвэрлэдэг байдаг тийм баймаар байх юм. Тэгэхээр энэ дээр жишээ нь бид алсыг хараад, улс орны хөгжлийг хараад, тулгарч байгаа асуудлыг шийдэхийн тулд Байнгын хороогоо хүртэл ингэж хиймээр байх юм. Бусад улсад яг л ийм байна шүү дээ. Ямар асуудал чухал байна тэрүүгээрээ тусдаа Байнгын хороотой байж байна.

Сая Бундестагийн 7, 8 гишүүд ирж байхад яг энэ асуудлыг хөндөж байгаа байхгүй юу. Манай улсын хувьд Герман улсын хувьд энэ асуудал чухал байгаа учраас энэ Байнгын хороо ажилладаг. Энэ нь өөрөө асуудлыг шийдээд, тэр нь 5, 6 жилийн дараа асуудал байхгүй болдог. Гэтэл бид нарт нөгөө л Нийгмийн бодлогын байнгын хороо гэхэд Эрүүл мэндийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны тайлан сонсдог, нэг асуудлыг нь хариуцдаг гээд нэг Байнгын хороо. Эдийн засгийн байнгын хороо гэхээр нэг тухайн салбарын яамдын тайлан сонсдог болохоос биш улс орны өмнө тулгарч байгаа асуудлыг шийдээд ингээд энийг ингээд явчихъя, Засагтаа хариуцлага тооцъё, эсвэл Засгаа дагуулаад энийг хийчихье гэдэг зүйлүүд ингээд орхигдоод байна л даа. Тэгээд бид бол парламентын засаглалтай орно. Тэгэхээр энэ дээр илүү их анхаарч, бас бид нар одоо ийм боломж байгаа дээрээ энэ хуулийн төсөл дээрээ анхаарч ажиллавал их зүгээр байна гэсэн

саналаа би илэрхийлж байгаа юм. Баярлалаа.

**Н.Энхболд:** Баярлалаа, санал. Түүрүүн би ганцхан юм хэлчихье. Нөгөө анхны төслөөр бид нар оруулдгийг 8 Байнгын хороотой гээд оруулж байсан л даа. Тийм ээ тийм. Тэгээд бүлэг дээр яриад бас дахиж төсөл хэлэлцүүлэг авч, гишүүдээс, бүлгүүдээс гарсан саналыг харгалзаад ямар ч байсан одоогийн байгаа хэмжээндээ оруулъя. Тэгээд дараагийн Их Хурлын бүрэн эрхийн асуудал болохоор тэр үед нь яг сая таны ярьсан шиг тухай тухайн асуудлуудаараа Байнгын хороо байгуулаад явна гэвэл өөрсдийнх нь мэдлийн асуудал, эрх мэдлийн хүрээнд байж байгаа, тийм. Зүгээр энэ юмыг бас нэг зүйл анхааруулж хэлэхэд, анхааруулж ч гэж дээ сануулж хэлэхэд бид нар Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан нэг заалт болбол төрийн бодлого, төлөвлөлт тогтвортой байна гэсэн ийм заалт орчихсон. Энэ хүрээндээ Алсын хараа 2030, 50 гээд ийм бодлогуудыг тусгачихсан байж байгаа. Тэгэхээр дараагийн тэр бодлогууд дотор сая таны ярьсан зүйл бүгдээрээ орсон байж байгаа. Тэр бодлогуудын хүрээнд ямар Байнгын хороотой ажиллахаа бас шийдэх боломж нь дараагийн Их Хуралд байж байгаа. Зүгээр энэ одоо хэлэлцүүлгийн явцад та бүхний зүгээс үүнийг нь оруулаад дараагийн хуралд шилжүүлчихмээр байна гэсэн санал байвал бас энэ нээлттэй байж байгаа. Өнөөдөр бид нар хэлэлцэх эсэхээ л ярьж байгаа. Ганболд гишүүн.

**Г.Ганболд:** Яах вэ өмнө нь бас 2, 3 удаа л хэлэлцээд, уг нь нэг зарчмын хувьд нь хэд хэдэн юмнуудыг өөрчилж оруулахаар л болсон санагдаад байх юм. Тэгээд нэг их өөрчлөлт оруулаагүй л зарим юмнууд байна л даа.

**Н.Энхболд:** Одоо санал хураана шүү.

**Г.Ганболд:** Хяналт шалгалтын хууль дээр тухайн асуудлаар үгүй ээ, яллах дүгнэлт үйлдэж шүүхэд

шилжүүлсэн эрүүгийн хэрэгтэй холбоотой асуудлаар Түр хороо байгуулахыг хориглоно гээд энийг чинь бид нар ярьж байгаад энэ Энхбаяр гишүүн.../үг тасрав/

**Н.Энхболд:** Чимээгүй байгаарай. Би сонсьё.

**Г.Ганболд:** Та нар юм яриул л даа. Тэгээд өмнө нь ярьсан юмнуудаа ингээд засаж барьсан юм байгаа юм уу энэ чинь. Одоо энэ яллах дүгнэлт үйлдэж шүүхэд шилжүүлсэн эрүүгийн хэрэгтэй холбоотой асуудлаар Түр хороо байгуулахыг хориглоно гэж байгаа шүү дээ. Тэгээд энийг болохгүй гээд хэдүүлээ яриа биз дээ. Бүгд дээр нь гялс одоо ингээд л асуудал гараад ирэнгүүт нь яллах дүгнэлт үйлдээд л, шүүхэд шилжүүлчихнэ шүү дээ. Бид нар чинь энэ шүүх дээр очоод гацчихсан, ужиг болсон, удчихсан явахаа байсан юмнууд дээр чинь Түр хороо байгуулж энэ Хөгжлийн банк чинь тэгсэн шүү дээ. Өчнөөн шалгаад удаад, хэдэн жил болохоор нь араас нь Түр хороо байгуулаад л шалгасан санагдах юм. Тэгээд энэ үүгээр болбол маш олон зүйлүүд дээр аль хэдийн л эрүү үүсчихсэн л байж байна даа энэ, дуулиан болоод тэгээд нэлээн ужгираад ирэхээрээ л дуулиан болж байгаа шүү дээ. Тэгээд энийг уг нь хэдүүлээ ярьсан санагдах юм.

Тэр Байнгын хороон дээр зарчмын зөрүүтэй санал 2 хоногийн өмнө гаргана гээд. Үгүй ээ бид нар чинь яг бодит амьдрал дээр энэ материал чинь 2 хоногийн өмнө битгий хэл өнөөдөр л ирдэг шүү дээ. Тэгэхээр 4 хоногийн өмнө ядаж энэ Байнгын хороод хэлэлцэх хуулиудаа гишүүдэд өгч байж, 2 хоногийн өмнө тэр зарчмын зөрүүтэй санал авна шүү дээ. Тэрийг хэдүүлээ өмнө нь яриад л больё л гэсэн. Тэгээд энэ дээр хэдүүлээ нэг ойлгомжгүй байгаа юм одоо энэ Их Хурлын гишүүд, Их хурлын гишүүд нөгөө чуулган эхлэхийн өмнө тухайн өдөр хэлэлцэх асуудалтай холбогдуулж үг хэлдэг шүү дээ. Энийг маш ойлгомжтой болгохгүй бол манай энэ Пүрэвдоржоос

өгсүүлээд л 5 дахь асуудлыг 1 рүү оруулъя гэж санал өгчхөөд л, тэгээд л шал өөр юм яриад л явчихдаг шүү дээ ер нь болбол нарийндаа. Тэгээд энийг хэдүүлээ цэгцлэх гэж байгаа бол их тодорхой болгомоор байгаа юм.

Тэгэхгүй бол бүх гишүүд ингээд дотор асуудлыг нь 5 дахийг нь 1-д оруулъя, 1 дэхийг нь 4-т оруулъя гэж саналаа өгчихнө. Тэгээд л ерөөсөө өглөөний хурал эхлэхгүй, бүгдээрээ үгээ хэлээд л ингээд. Үг хэлэхийг нь нөгөө бүлгүүдэд өгчхөж байгаа учраас гишүүдийн чинь ганц боломж нь тэр л болно л доо. Тэгэхээр бүгдээрээ өглөө ингээд л хурал эхлэхгүй, үг авах гээд л ингээд л суучихна шүү дээ. Тийм, 5 дахь асуултыг 1 рүү оруулъя гээд л саналаа биччихнэ. Тэгвэл хэлэлцүүлэх нь зөв гээд л үгийг үг өгнө шүү дээ. Тэгээд л шал өөр юм яриад л явчихна, микрофон асаалгаж аваад л, тийм. Тэгэхээр энийг болбол ерөөсөө маш тодорхой, эсвэл бүр хаах хэрэгтэй байхгүй юу. Үг хэлүүлэхгүй, ингэж болно даргаа. Үг хэлэхгүйгээр саналаа өгчих юм бол тэрүүгээр нь л шууд санал хураагаад л, 5 дахийг нь 4 рүү оруулна гэж байна санал хураая гээд л үгүй бол үгүй, үг хэлүүлэхгүй тийм. Үгүй ээ үгүй, тэгэхдээ тэр чинь нөгөө санал хураах тийм ерөөсөө үг огт өгөхгүйгээр л, тийм. Тэгэхгүй бол манай Пүрэвдорж бол тэгээд л явна шүү дээ мэдээж, шал өөр юм яриад л тэгээд л ингээд л алга болно.

Тэгээд байна шүү дээ энэ гишүүний, гишүүнд хориглох үйл ажиллагаа гэсэн нэг юм байх юм. Тэгээд нэг баахан ингээд л хориглосон, хязгаарласан. Тэгээд энэ дотор нэг ойлгомжгүй юмнууд их байна. Энэ гишүүдийн үйл ажиллагаанд хориглох гэдэг юмнууд дээр. Энийг ер нь нэг цөөхөн хэдэн юмнуудыг их ойлгомжтой байлгахгүй болбол бусдад давуу байдал олгох гэж гээд л энэ ойлгомжгүй нэг юм. Үгүй ээ бид нар чинь жишээлбэл Их Хурлын гишүүний үндсэн үүрэг болбол тойргийн сонгогчдын хүсэлтийг л ингээд л холбогдох байгууллагуудад нь уламжлах



үүрэгтэй шүү дээ. Тэгээд л энэ чинь буцаад л эрүүгийн хэрэг болгодог бусад давуу байдал олгосон гээд л. Тийм энэ ингээд гишүүдийн хориглох үйл ажиллагаа гэдэг юмнуудаа нэг жсоохон, одоо ингээд л тийм. Тэгээд л ингээд л Аж ахуйн нэгж эрхлэгчдийн холбоо янз бүрийн юманд орохгүй гээд л ингээд л. Одоо яг.../минут дуусав/

**Н.Энхболд:** Би товчхон, товчхон хариулаад явъя Ганболд гишүүний юунд. Энэ тэр нөгөө нэг эхэнд үг хэлдэг асуудал дээр ийм зохицуулалт хийж байгаа юм. Гишүүд бас тодорхой хугацааны өмнө 2 хоногийн өмнө бичгээр Даргын зөвлөлөөс ингээд хэлэлцэх асуудлын жагсаалт гарч байна шүү дээ. Тэгэхээр бичгээр саналаа өгнө. Би ийм асуудлаар үг хэлмээр байна гээд, яг хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой үндэслэл, тайлбартайгаар. Түүнээс зүгээр байр сольё ч гэдэг юм уу, харин тийм. Тэгэхээр ингэнэ. Тэгэхээр ингэх юм байгаа юм. Би 2 юм хэлэх гээд байна шүү дээ. 1 дүгээрт тэр шууд үг хэлдгийг нь болиулж байгаа юм. Даргад саналаа өг. Их Хурлын дарга бас тодорхой хэмжээний эрхтэй. Өөрөө хурлыг зохион байгуулах, зөв явуулах, цагтаа багтааж асуудлаа хэлэлцүүлэхийн тулд. Өөрөө үзээд энэ болбол хэлэлцэх асуудалтай холбоогүй юм байна. Зөвхөн дараалал солих энэ тэр болбол амархан асуудал л даа. Тэгээд энүүгээр, энүүгээр ийм, ийм бичгүүд ирсэн байна. Энэ нь бол хэлэлцэх асуудалтай холбоогүй юм байна, энэ нь бол холбоотой юм байна. Тийм учраас олонхын саналаар шийднэ гээд санал хураагаад, үг хэлнэ гэвэл хэлүүлбэ гэвэл хэлүүлнэ, хэлүүлэхгүй гэвэл хэлүүлэхгүй ийм зохицуулалт орж байгаа юм. Нэг алхам ядаж. Энэ зохицуулалт дээр.

Тэр 2-оос 4 хоногийн өмнө гэдэг болбол одоо ч гэсэн хуульд тийм зохицуулалт бий. Харамсалтай нь зарим хуулийг өнөөдөр өргөн мэдүүлчхээд л маргааш бариад байгаа болохоос. Тэгээд энийг ерөөсөө л дэг бариулах тал дээр Улсын Их Хурлын удирдлага, холбогдох Тамгын газар сайн сануулаад Их Хурлын

дарга, Тамгын газар энд хяналт тавьж, яг хуульд заасан хугацаанд гишүүдэд материалыг нь тарааж өгч байх тухай л асуудал байгаа юм. Түүнээс одоо ч ийм заалт бий.

Тэр шүүхтэй холбоотой асуудал. Тэгээд сүүлдээ нөгөө нэг хамааруулах энэ болбол зөвхөн Их Хурлын гишүүдтэй ч холбоотой биш. Ерөөсөө энэ нэг хамаарал бүхий этгээд гэдэг утгатай Эрүүгийн хуульд орсон заалт юмнуудыг бид нар их нарийвчилж тогтоохгүй болбол яг үнэнийг хэлэхэд би энэ миний хувийн байр суурь. Энэ нийгэмд үүсээд байгаа хулгай зэлгий, Их Хурлын гишүүд, улс төрчид, нөлөө бүхий этгээдүүдийн зүгээс гарч байгаа энэ их нийгэмд үүсгэчихсэн буруу, буруу ч гэж дээ үүсгэчихсэн бухимдал энэ зүйлүүдийг бас тодорхой хэмжээгээр юм уу харгалзаж үзээд л бид нар бүгдээрээ ярьж байгаад л суугаад л хуульд оруулчихсан заалтууд шүү дээ. Тэгэхээр ганц Их Хурлын тухай хуультай ч холбоотой эд биш юм байгаа юм. Жишээ нь сая Сүхбаатар гишүүн хэлж байна. Би бол үнэндээ ингээд л зүгээр нөгөө хамаарал бүхий этгээд гэдэг юмаар л асуудалтай тулчхаад сууж байна шүү дээ. Тэгэхээр энийг бол зөвхөн Их Хурлын тухай хуулиар биш бусад их, бусад хуулиудтайгаа уялдуулж их нарийн ярьж байж зохицуулах ёстой юм байна лээ. Зүгээр яг Их Хурлын тухай хуульд гишүүдийн хувьд ч гэсэн ийм байгаа. Өөрсдөө нөгөө төрийн өндөр албан тушаалтнууд учраас бас энэ хамт хамрагдчихаад яваад байгаа шүү гэдгийг хэлчихье. Тийм. Тэр бусдад давуу байдал олгох, хамаарал бүхий этгээд энэ тэр болбол ийм учиртай байна. Пүрэвдорж гишүүн яах юм бэ? Болих уу? Үг хэлэх гишүүн байна уу? Байхгүй байна. Тэгвэл саналаа хураачихъя. Оюунчимэг саналаа өгчих тийм.

Улсын Их Хурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэж үзэж байгаа гишүүд саналаа өгье. Санал хураалт. Тогтохсүрэн гишүүнийхийг оруулаад, 11 гишүүн санал



өгснөөс 8 дэмжиж, санал дэмжигдлээ. Байнгын хорооны санал, дүгнэлтийг Жаргалмаа гишүүн, дараа нь ахиад 2 хууль байгаа, уншихаар зохицуулъя. Баярлалаа. 1 дүгээр асуудал дууслаа. Одоо дэгийн, түрүүн нэг юу яасан юм. Түрүүн дахиж энд энэ дээр тоо гарахгүйгээр засаж, нэг удаа яасан юм. Харин тийм орж ирж хэлэхгүй та нар.

11.06 цаг

**Хоёр.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нарын 3 гишүүн 2024.04.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх**

Дараагийн асуудалдаа оръё. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэлэлцэж эхэлье. Хууль санаачлагчийн илтгэлийг би хийе. Энэ хуулийг мөн Мөнхбаатар гишүүн, би, Тэмүүлэн гишүүн боловсруулж өргөн мэдүүлсэн байгаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг 24 оны 4 сарын 3-ны өдөр сая нэр дурдсан гишүүд боловсруулж, өргөн мэдүүлсэн. Үндсэн хуулийн 20 дугаар зүйлд Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага, хууль тогтоох эрхийг гагцхүү Их Хуралд хадгална гэж. Мөн 25 дугаар зүйлийн 4-д Их Хурлын бусад бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно гэж Үндсэн хуульд зааснаас бусдыг нь хуулиар тогтооно гээд биччихсэн байж байгаа. Тэгээд 5 сарын 31-ний өдөр энэ оны Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг баталсан. Тэр өөрчлөлтөөр 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг бүхэлд нь өөрчилж, Их Хурал нэг танхимтай 126 гишүүнтэй байна. Их Хурлын сонгуулийг холимог тогтолцоогоор явуулна. 78 гишүүнийг олныг төлөөлөх, 48 гишүүнийг хувь

тэнцүүлэн төлөөлөх аргаар сонгоно гэж ингэж заасан.

Мөн Их Хурлаас 23 оны 5 сарын 31-ний өдөр баталсан Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн нэгд Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг 24 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн дагаж мөрдөнө. 3 дугаар зүйлд нь Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтөд нийцүүлэн холбогдох хуульд өөрчлөлт оруулах болон шинэчлэн баталж мөрдөх хүртэл тухайн харилцааг зохицуулж ирсэн хуулийг дагаж мөрдөнө гэж заасан. Тэгээд энэ өөрчлөлтөөр Их Хурлын зохион байгуулалт, гишүүдийн тоо өөрчлөгдөж байгаа. Үүнтэй уялдуулаад чуулганы нэгдсэн, Байнгын, дэд, түр хорооны хуралдаан зохион байгуулах, хуралдаанаар хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл, тодорхой асуудлуудыг хэлэлцэх, санал хураах, шийдвэр гаргахтай холбогдсон харилцаанд зохион байгуулалтын шинжтэй холбогдох өөрчлөлтүүдийг тусгах шаардлага үүссэн.

Мөн Дэгийн хуулийн шинэчилсэн найруулгыг хэрэглэх явцад зарим зохицуулалтыг илүү тодорхой болгох, нарийвчлах, нэр, томъёог нь Үндсэн хууль, бусад хууль, Монгол хэлний дүрэмд нийцүүлэх, жигдлэх техникийн шинжтэй, хууль зүйн техникийн шинжтэй зарим засвар оруулах ийм практик хэрэгцээ шаардлага байсан учраас энэ Дэгийн тухай хуулийг шинэчилж найруулсан. Ингэхдээ бас Их Хурлын өнгөрсөн 8 удаагийн сонгуулиар байгуулагдсан Их Хурлуудын үйл ажиллагаанд дэг нь яаж мөрдөгдөж байсан, яаж, ямар бэрхшээл, ямар асуудлууд тулгарч байсан энэ зүйлүүдийг харгалзаж үзсэн. Бусад орнуудын туршилагаас бас боломжтой тохиромжтой гэж үзсэн зарим зүйлүүдийг судалж үзээд оруулсан байгаа гэдгээ хэлье.

Зарчмын шинжтэй нэлээд олон зүйлүүдийг тусгасан, 16 бүлэгтэй, 136

зүйлтэй ийм хуулийн төсөл байгаа. Хуулийн шинэчилсэн найруулгаар хуралдаанаар хуралдааны дэг тогтоох нийтлэг тийм жишигт нийцсэн мэтгэлцээний зарчмыг тусгасан. Нам, эвслийн бүлгээс санал, дүгнэлт гаргахдаа үзэл баримтлалын хүрээнд мэтгэлцэх шаардлагатай гэж үзсэн тохиолдолд хэлэлцэх эсэх, анхны хэлэлцүүлгийн үе шатуудыг мэтгэлцэх зарчмаар явуулах ийм зохицуулалтыг тусгасан байгаа. Хэлэлцэх хууль, тогтоолын төслийг хэлэлцэх үе шатын зохицуулалтыг боловсронгуй болгож, чуулганы хуралдааны тов дарааллыг тогтоох, түүнийг гишүүдэд мэдээлэхтэй холбоотой зохицуулалтуудыг урьд өмнөх туршлагатайгаа харьцуулж үзээд нарийвчилж тодорхойлсон. Хуулийн төслийг хэлэлцэх дарааллын тогтоохдоо өргөн мэдүүлсэн хугацааг нь харгалзан үздэг байх тухай заалт нэмж орсон. Бүрэн эрхийн хугацаанд хэлэлцэж батлаагүй хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг тэр тухайн Их Хурлын бүрэн эрхийн хугацаа дуусангуут буцаах ийм зохицуулалт өгсөн. Одоо болбол ингээд байгаад байдаг. Нөгөө олон хүн хамтраад өргөчихсөн хуулийн төсөл байж байхад, тэрнээс нэлээд хэсэг нь дахиж сонгогдоогүй ч гэсэн нөгөө хуулийг нь хэлэлцэх асуудлын хүрээнд байгаад байдаг нэг ийм зүйлүүд байдаг. Тэгэхээр шинэ Их Хурал өөрөө энийг шаардлагатай гэж үзвэл шинээр боловсруулаад оруулах хэрэгтэй. Хуучин төслийг болбол буцаах ийм зохицуулалт тусгасан байж байгаа.

Улсын Их Хурлын Тамгын газраас холбогдох Байнгын хороо хууль, тогтоолын төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулахын өмнө хууль, тогтоолын төсөл Үндсэн хууль болон бусад хуульд нийцэж байгаа эсэх тухайн хуулийн төслийн тодорхой зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилдсөн эсэх, хүчингүй болгох, нэмэлт, өөрчлөлт оруулах, хуулийн төсөлд шаардлагатай бүх хууль зүйл, хэсэг, заалтыг хамааруулсан эсэх зэрэг асуудлаар хууль зүйн дүн шинжилгээ дүгнэлт гаргадаг

байх зохицуулалт орсон. Мөн Байнгын хорооны хүсэлтээр хууль хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо, улсын төсөвт үзүүлэх нөлөөллийн дүн шинжилгээ дүгнэлт хэрэгтэй байна гэж үзвэл ийм дүгнэлт гаргуулж байх үүргийг, эрхийг Байнгын хороонд өгсөн байж байгаа. Ингэснээр Их Хурлаас хуулийн төслийг чанартай, хийдэл багатай батлагдах ийм нөхцөл бүрдүүлнэ гэж үзэж байна.

Их Хурлын гишүүдийн тоо нэмэгдсэнтэй холбогдуулаад асуулт асуух, үг хэлэх, санал хураах журам, хугацаанд холбогдох өөрчлөлтүүдийг санал болгож байгаа. Хуулийн төсөл хэлэлцэх үед нэгдсэн хуралдаанд асуулт асуух нийт хугацааг Улсын Их Хуралд заасан нийт хугацааг тогтоогоод, тэгээд Улсын Их Хуралд нам, эвслийн бүлгүүдийн авсан суудлын тооны харьцааг нь харгалзаад тухайн нам, эвслийн бүлэгт өгч байх, бүлэгт харьяалагддаггүй гишүүдэд мөн хувь тэнцүүлэн тэдэнд ноогдох нийт цагийг нь хуваарилаад тэр үгээ, үг хэлэх, асуух хугацаагаа хуваарилж байх ийм зарчмуудыг тусгасан. Ингээд энэ зарчмыг мөрдвөл асуулт асуух, үг хэлэх гишүүдийн нэрсийг нэгдсэн хуралдааны өмнөх өдөр хуралдаан даргалагчид бүлэг, эвслүүд, биеэ даасан гишүүд мэдэгдэж байх ийм зохицуулалтыг тусгасан байгаа.

Нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд нь хэлэлцэхийг дэмжээгүй болбол тэр хуулийн төслийг тодорхой хугацааны дотор дахин өргөн мэдүүлэхгүй байх зохицуулалтыг тусгасан.

Улсын Их Хурлын гишүүн нам, эвслийн бүлэг хууль, тогтоолын төсөлд зарчмын зөрүүтэй санал гаргах болбол саналаа Байнгын хороонд хууль, тогтоолын төслийн анхны хэлэлцүүлэг явуулахаас тодорхой хугацааны өмнө бичгээр урьдчилан мэдүүлж байх. Байнгын хороо төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэхдээ хууль

хоорондын уялдааг хангуулахаар бусад холбогдох хууль нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулан хамтад нь хэлэлцүүлж болох энэ зохицуулалтыг тусгасан байгаа. Одоо бол үндсэндээ орж ирсэн хуулиудын хүрээнд ярьдаг, шинэ зохицуулалтаар болбол хэрэв хэлэлцүүлэх явцад хууль шийдвэрийн үзэл баримтлалыг нь хүрээнд нь хэлэлцэхэд ийм өөрчлөлт хийх хэрэгтэй байна гэж үзвэл Байнгын хороо бас санаачлаад оруулж болох хуулийн төслийг танилцуулж байгаа юм.

Сахилга хариуцлага, дэг сахихтай холбоотой зарим зохицуулалтыг шинэчилж тусгасан. Онцын өөрчлөлт ороогүй. Гэхдээ бас жоохон тодорхой болгосон зүйлүүд бий. Мөн хэрэглээг ойлгомжтой болгоход чиглэсэн бүтэц, нэр томъёо, хууль зүйн техникчтэй бусад өөрчлөлтийг тусгаад, чуулганы хуралдааныг зохион байгуулах нийтлэг журам, олон улсын гэрээ байгуулах санал, гэрээний төслийг хэлэлцэх, гадаад харилцаатай холбогдох асуудал хэлэлцэх зэрэг биеэ даасан бүлгүүдийг нэмсэн. Эрдэнэсийн сангийн төсөв хэлэлцэх, Ерөнхийлөгч Улсын Их Хуралд тангараг өргөх, Улсын Их Хурлын хяналтын сонсголыг зохион байгуулалттай холбоотой зарим зохицуулалтыг нэмсэн. Бүтцийн хувьд үүнтэйгээ уялдсан өөрчлөлтүүдийг хийсэн байгаа.

Ингээд та бүхнийг Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн, шинэчилсэн найруулга, түүнтэй холбогдуулж хамт өргөн мэдүүлж байгаа хуулийн төслүүдийг үзэл баримтлалынх нь хүрээнд хэлэлцэх эсэхийг шийдвэрлэж өгөхийг хүсэж байна. Анхаарал тавьсанд баярлалаа. Хуулийг боловсруулсантай холбогдуулж санаачлагчийн танилцуулсан илтгэлтэй холбогдуулж асуух гишүүд нэрээ өгье. Жаргалмаа гишүүн, Туваан гишүүн. Жаргалмаа гишүүний микрофоныг өгье.

**Б.Жаргалмаа:** Дарга би хуулийн төслөө бол дэмжээд явна. Нэг зүйлийг

тодруулах гэсэн юм. Энэ Байнгын хорооны даргад Байнгын хорооны гишүүдийн дотроос олонхын саналаар нэр дэвшүүлнэ гэсэн нэг ийм заалт байгаа. Байнгын хорооны даргаа сонгохдоо. Эндээ шүүд нэр дэвшүүлээд Байнгын хороон дээрээ батлахгүй шүүд Их Хурал руу орно гэсэн үг үү? Байнгын хороон дээр санал хураалт байхгүй гээд.

Нөгөөтээгүүр энэ 32.4 дээр өмнөх Улсын Их Хурлын бүрэн эрхийн хугацаанд хэлэлцэж батлаагүй хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаасанд тооцно гэнэ. Магадгүй өнөөдөр өргөн барьсан энэ парламент өргөн барьсан хуулийн төслийг хэлэлцэж амжилгүйгээр дараагийн парламент руу шилжихэд хуулийн төсөл өргөн барьсан тодорхой тооны гишүүд нь улиран сонгогдсон, дахин сонгогдсон байвал гэдэг ийм заалт байх ёстой юу, үгүй юү гэдэг зүйлийг тодруулах гэсэн юм. Яагаад би ингэж асуугаад байна вэ гэвэл Гэр бүлийн тухай хууль одоо яг нэг хүлээлттэй байгаа. Бид нар бас яг хэлэлцэж амжих эсэхээ шийдэж чадаагүй байгаа. Тэгэхээр энэ дээр зүгээр ийм тодруулга асуух гэсэн юм.

**Н.Энхболд:** Байнгын хороон дээр хорооноос нэр дэвшүүлнэ гэдэг нь олонхоороо яриад шийдээд, нэгийгээ санал хурааж сонгоод, энэ хүн манай Байнгын хорооны гишүүдийн олонхын санал авлаа гээд чуулганд тийм, чуулганд оруулаад, тэгээд шийднэ гэсэн ийм зохицуулалт байгаа.

Буцаах заалтын хувьд бол бид нар яах вэ ярьж байгаад одоо жишээ нь өнөөдөр тухайлбал манай хороон Байнгын хороон дээр хэдэн хууль байна. Өмнөх Их Хурлаас Их Хурлын үед өргөн мэдүүлчихсэн хэд хэдэн хууль шийдвэрийн төслүүд байж байгаа байхгүй юу. Тэгээд, үгүй ээ хэлэлцэх боломж байхгүй. Гишүүд нь дахиж сонгогдоогүй, сонгогдоогүй бол автоматаар явуулж байгаа. Хамт нийлээд өргөн мэдүүлчихсэн байдаг. Магадгүй 5 хүн өргөн мэдүүлчихсэн

байсан чинь 2 нь сонгогдоогүй, 3 нь сонгогдчихсон бол тэр үлдчихээд байгаа юм. Тэгэхдээ хэлэлцүүлэг гэхээр явуулах гэхээр дэмжлэг авахгүй байгаа юм. Тухайн Их Хурлаас явуулж байгаа юу гэдэг юм бодлого юмтай нийцэхгүй байна ч гэдэг юм уу. Их Хурал, тэр Их Хурал нь энийг хэлэлцэх шаардлагагүй гээд үзчихсэн байхад нөгөө хүний юмыг чинь хэлэлцэж болохгүй, хэлэлцэж болохгүй ингээд орхигдчихоод байгаа байхгүй юу. Тэгэхээр ямар ч байсан ер нь болбол тэр Их Хурлаараа л хэлэлцээгүй болбол тэгээд орхиж байя.

Дараагийн Их Хуралд жишээ нь олуулаа нийлж байгаад 1 нь ч гэсэн үлдсэн байвал би үүнийг заавал хэлэлцүүлнэ гэж үзвэл дахиад л өргөн мэдүүлэх боломж нь байж байгаа. Гишүүд нь огт, дахиж сонгогдоогүй эсхүл олон хүнээс цөөнх цөөн нь үлдчихсэн болбол тэрийг автоматаар хэлэлцэхгүй байх ийм л зохицуулалтыг тусгаж өгөхгүй болбол одоо заалт байхгүй учраас ингээд агаарт хоосон өлгөчихсөн юм шиг ийм байдалтай орхигдчихоод байгаа юм. Тийм. Туваан гишүүн асууя.

**Ц.Туваан:** 3 хууль явж байгаа юм байна. Улсын Их Хурлын тухай хууль, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль, Хяналт шалгалтын тухай хууль гээд. Энэ дээр 2 тодруулах зүйл, 1 хэлэх санал байгаа юм. Эхнийх нь бол энэ бодит кэйс. Улсын Их Хурал дахь АН-ын бүлэг өөрөөр хэлбэл цөөнхийн бүлэг Улсын Их Хурлын даргад болон Улсын Их Хурлын Тамгын газарт бүгдээрээ гарын үсгээ зураад энэ Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, Дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, 3-д нь Улсын Их Хурлын тогтоолын төсөл гээд ийм 3 зүйл санаачлаад өгсөн. Тэгээд энийг өгснөөс хойш бараг 45, 50 хоног ингээд юу өргөн барих тов тогтоож өгөхгүйгээр ингээд гацааж байгаа юм. Энэ бол бас тийм Их Хурлын би бол Их Хурлын гишүүний бүрэн эрхт бас халдаж байгаа асуудал. Бүлгийн цөөнхдөө хүндэтгэлгүй хандаж

байгаа асуудал юм болов уу гэж ингээж ойлгож байгаа.

Өөр юм, өөр хууль дүрмүүд болохоор яаралтайгаар л гэнэ, ямар гэнэ вэ нэг урьд өдөр нь бариад л, маргааш нь ороод л шууд хэлэлцэгдээд л, анхны хэлэлцүүлгээрээ ингээд яваад байгаа. Тэгэхээр иймэрхүү асуудлууд байна. Тэгэхээр энэ дээр бас нэг юу гэдэг юм энэ чинь хэлэлцэх эсэх чинь Даргын зөвлөл дээр шийдэгдэнэ тийм ээ. Энэний өмнө тов тогтоох гээд нэг асуудал байгаа. Тэгэхээр энэ дээр энэ шинэ хууль дотор чинь ямар зүйл заалт орж байгаа юм бэ? Ер нь хуучин дээрээ бас ямар зохицуулалт байдаг юм бол? Бид хэд энийгээ бас товоо тогтоолгоод хэлэлцье гээд байдаг. Ялангуяа энэ ЗГ-аас шийдвэр гаргаад энэ дээр нөгөө онцгой байдлын зэрэг тогтоогоод яачихсан ийм маш яаралтай цаг алдахгүй ийм асуудлуудтай холбоотой ган, зуд, гамшигтай холбоотой асуудал өргөн барьж байгаа байхгүй юу. Тэгэхээр энийг ерөөсөө хэлэлцэхгүй ингээд товыг нь ч тогтоож өгөхгүй байгаа асуудал дээр нэг тодруулга авах гэсэн юм.

2 дугаарт нь энэ хэлэлцэх эсэхээ шийдээд, энэ ажлын хэсэг байгуулагдаад ингээд явах байх. Тэгээд бид хэд нэгэнт энэ Их Хурлын дарга зарим эрх юу олонх байгаа намын асуудал ингээд яаралтайгаар, нэн яаралтайгаар яваад байдаг, бид нарынх болохоор бүүр товоо ч тогтоож чадахгүй байгаа энэ асуудал дээр одоо яах вэ Байнгын хороон дээр зарчмын зөрүүтэй санал гаргах, мөн ажлын хэсэгт Их Хурлын гишүүнийхээ хувиар юмаа өгөөд л нэг явахаас даа гэсэн ийм бодол байна. Тэгэхээр ер нь бол энэ цаашидаа энэ Дэгийн тухай болон энэ чуулганы хуралдаанууд дээр бид нар чинь Их Хурлын гишүүд, тэр ард иргэддээ тохиолдсон янз бүрийн асуудлыг цаг алдалгүй шийдэхийн тулд тангараг өргөөд орж ирж байгаа гишүүд. Тэгэхээр энэ асуудлууд дээр бол жирийн асуудал бол бас хүлээж болох байх тийм ээ. Тэгэхээр энэ жилийн ойрын 60, 70 жил тохиолдоогүй зудтай холбоотой асуудал



дээр ч гэсэн бид нар ер нь бол цаг алдчихсан. Тэгэхээр ийм асуудлуудыг бас ирэх энэ шинэ хуульдаа бас сайжруулаад оруулчихвал яасан юм бэ? Энэ дээр бас нэг Байнгын хорооны даргын хувиар та нэг санал бодлоо хэлээч?

**Н.Энхболд:** Ер нь болбол хууль тогтоомжийн төслийг өргөн мэдүүлэх, хэлэлцэх дараалал, тов тогтоох асуудал одоогийн байдлаар бол Улсын Их Хурлын тухай хуулиар биш нөгөө Хууль тогтоомжийн тухай хуулиар зохицуулагдаад явж байгаа. Шаардлагатай гэж үзвэл дагуулж оруулах хууль дотроо тэрийг оруулж болно. Таны асуусанд тодорхой хариулахад жишээ нь дараалал тогтоохдоо юу харгалзах вэ гэдэг болбол бас жоохон тийм субъектив маягаар хандах ийм нүх цоорхой одоогийн дэгт байгаа байхгүй юу. Бид нар болбол мэдээж тусгаар дэгээр хэлэлцдэг асуудал болбол угаасаа Их Хурлынхаа, Их Хурлаараа ярьж байгаад хуульдаа тусгаад ийм, ийм асуудлуудыг онцгой тохиолдолд ЗГ-аас орж ирэхэд яаралтай хэлэлцүүлнэ гээд ингээд нэг дэг гаргачихсан тэрүүгээрээ явж байгаа.

Дараалал тогтоох юман дээр болбол энэ шинэ юунд би, бид нар оруулсан байгаа. Тэр нь юу вэ гэхээр өргөн мэдүүлсэн хугацаа, дарааллыг заавал харгалзана гээд. Жишээ нь оруулж ирж байгаа асуудал яаралтай гэж үзвэл яаралтай дэгээр хэлэлцэх үү, үгүй юү гэдгийг нь Их Хурал өөрөө шийдээд тэгье гэвэл шийдээд явчихна. Бусад хуулиудын хувьд болбол яг яаж дараалж өргөн мэдүүлсэн байна тэрүүгээр нь хойно, урд нь оруулахгүйгээр, түрүүлж орж ирснийг нь түрүүлж хэлэлцээд явж байх бололцоог нь хангаж байх нь зүйтэй гэсэн санаагаар тийм заалт үг, үгээр нь энэ шинэ Дэгийн хуульд орчихсон байж байгаа.

Ерөнхийдөө сая таны хэлсэн би зүгээр хууль санаачлагчийн хувьд биш, гишүүний хувьд бас хэлэх санаа бол мэдээж улс оронд яаралтай тийм

зүйлүүд зөндөө л гардаг. Би дахиад хэлэхэд хувь байр суурь төрийн байгууллагуудын хоорондын ажил үүргийн, эрх мэдлийн хариуцах хариуцлагын ялгаа зааг гэж байх ёстой. Гүйцэтгэх засаглал юугаа яаж хийж байх юм, хууль тогтоох нь яаж хийж байх юм гэдгийг. Тэрийг харгалзаж үзээд аливаа хууль тогтоомж, шийдвэрийн төслийг гишүүд юм уу, бүлэг, эвслийн зүгээс өргөн мэдүүлэхдээ бас бодож байх ёстой юм болов уу нэг зүгээр миний л ажигласан зүйл гэхээр. Магадгүй зарим тохиолдолд ЗГ-ын эхлээд ЗГ тодорхой хэмжээний арга хэмжээ аваад, үнэхээр тэр нь болохгүй болбол Улсын Их Хурал заавал оролцож байхаар, ЗГ-ын шийдвэрийг хүчингүй болгох эрх хүртэл Улсын Их Хуралд бий шүү дээ тийм ээ. Тэрийгээ хэрэглээд хүчингүй болгоод, дахиад өөр ийм байдлаар зохион байгуул гэж оруулах энэ эрх нь бол Улсын Их Хуралд байж байгаа. Түрүүн та бас надтай ярьж байсан, ийм хууль санаачлаад юманд оруулбал яах вэ гээд. Тэр таны эрх нээлттэй байж байгаа. Одоо хэдүүлээ ажлын хэсэг байгуулна. Тэгээд дэгд ийм хуулийн заалт нэмж оруулъя гэсэн санал, ажил байвал ажлын хэсэгт өгөөд, хэдүүлээ үргэлжлүүлээд хэлэлцээд явах юм нээлттэй байгаа. Туваан гишүүн.

**Ц.Туваан:** Тэгэхээр тийм одоо бас нэг хуулийн цоорхой, шийдэх ийм боломжгүй ийм цоорхой байгаа юм байна гэж ойлгож байна. Дээрээс нь субъектив хандлага ч бас байхыг үгүйсгэхгүй байгаа юм байна. Би бол энэ хэлэлцэх хуулийн дарааллын хувьд бол ойлгочихлоо. Дарааллаа авах гээд ингээд хуулиа өргөн барих гээд тов тогтоолгох хүсэлтээ бүх бичиг баримтаа бүрдүүлж өгчхөөд, 50 хоног хүлээж байгаа байхгүй юу. Тэгээд хэлэхээр одоо авна, тэдэн цаг, эдэн цаг гэххээд ингээд авдаггүй. Тэгэхээр энэ дээр энэ тов тогтоох асуудал чинь бол хэлэлцэх асуудал Даргын зөвлөлөөр орж хэлэлцэх асуудлаас тусдаа нэг асуудал болчхоод байна л даа. Тэгэхээр энэ дээр тогтоохгүй байгаа юм уу эсхүл тов өгөхгүй байгаа үед ямар



арга хэмжээ авах юм бэ? Би бол жишээлбэл одоо мэдэхгүй болчхож байгаа юм. Жишээлбэл Их Хурлын даргаас нэг Их Хурлын гишүүн байж нэг тийм хүнээс нэг юм гуйж байгаа юм шиг ингээд л яах вэ даргаа гээд л нэг царайчилж байгаа маягтай ингээд л очих юм.

**Н.Энхболд:** Яах вэ одоогийн хуульд болбол албан бичгээ өгчхөөд л, хүлээгээд л бид нар суугаад байгаа шүү дээ. Тэр тохиолдолд дараа нь яах вэ, үгүй ээ яах вэ санал оруулж болно. Ажлын хэсэг дээрээ ярихгүй юу та нар. Бид нар болбол оруулаагүй байгаа. Ер нь зүгээр яагаад би жишээ нь яагаад энийг оруулаагүй вэ гэхээр аливаа ер нь манайхаас бараг бусад парламент томоохон парламентууд болбол Улсын Их Хурлын дарга нь өөрөө маш том эрх мэдэлтэй тийм субъект байдаг юм. Тэр хурлыг яаж зөв зохион байгуулж явуулах вэ гэдэг дээр. Субъектив гэхээсээ илүү Их Хурлын даргад өөрт нь олгогдчихсон том эрхүүд байдаг байхгүй юу. Тийм эрхүүд, тийм эрхүүд Улсын Их Хурлын даргад байх уу, үгүй юү гэдгийг тэгээд хууль хэлэлцүүлэх явцдаа ярина биз, ярина биз. Тэгээд тэр бол нээлттэй байгаа гэдгийг л хэлээдэхье. Гишүүд асуулт асууж дууслаа. Үг хэлэх гишүүн байна уу? Үг хэлэх гишүүн алга. Санал хураалт явуулъя.

Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэж гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 11 гишүүн санал хураалтад оролцож, 7 дэмжиж, 63,6 хувиар дэмжлээ. Байнгын хорооны санал, дүгнэлтийг Сарангэрэл гишүүн танилцуулчих уу? Санал, дүгнэлт өнөөдөр шүү дээ. Сүхбаатар танилцуулах уу? Сүхбаатар гишүүн. Саяын 2 санал хураалт хоёулан дээр нь гишүүдээ 2 хуулиа хамт өргөн мэдүүлсэн хуулиудынх нь хамт үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх тухай асуудлаар санал

хураасан шүү. Тэгж ойлгож саналаа өгсөн гэж ойлгож байгаа.

11.28 цаг

**Гурав. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нарын 3 гишүүн 2024.04.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/**

Дараагийн асуудалдаа оръё. Баярлалаа. Сүхбаатар гишүүн уншина санал, дүгнэлтийг. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаарх хууль санаачлагчийн илтгэлийг та бүхэнд товч танилцуулъя.

Их Хурлаас 19 оны 11 сарын 14-ний өдөр баталсан Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн үзэл санааны дагуу Их Хурлын хяналт шалгалтын анхдагч хуулийг 21 онд баталсан. Ингэснээр Их Хурлын хяналт шалгалтын үйл ажиллагааны нэгэн шинэ үе шат эхэлсэн. Хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн дагуу Улсын Их Хурал хяналт шалгалтын бүрэн эрхээ хуульд заасан 7 арга хэрэгслээр дамжуулан хэрэгжүүлж байгаа. Нийт өнгөрсөн хугацаанд жишээ нь 23 оны намрын ээлжит чуулганы хугацаанд гэхэд Их Хурлын 6 гишүүн 64 асуудлаар 7 удаа асуулга тавьж, 2 асуулга нэгдсэн хуралдаанаар хэлэлцсэн. Мөн хугацаанд 2 гишүүн 20 асуудлаар 4 асуулт тавьж байсан байна.

Ер нь 19 онд Үндсэн хуульд орсон нэмэлт, өөрчлөлтөөр энэ бодлого төлөвлөлт тогтвортой байхаар заагаад, түүнд нийцүүлж хөгжлийн болоод төсвийн бодлогын баримт бичгийг харилцан уялдаатай төлөвлөх, тогтвортой байлгах энэ зарчим шаардлагуудыг хуульчилсны дагуу баримт бичгийн хэрэгжилтийг Улсын Их

Хурлаар хэлэлцэх үйл ажиллагаанд тодорхой ахицууд гарч байгаа гэж үзэж байгаа. Энэ бүх зүйлүүдийг харгалзаж үзчихсэн. Их Хурлын хяналт шалгалтын хүрээнд хяналтын сонсголыг зохион байгуулж, олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, хяналтын үйл ажиллагааг ил тод, нээлттэй байх нөхцөл бүрдүүлсэн. Их Хурлаас 20-оос 22 онд ерөнхий хяналтын 2 нэр, дэвшигчийн 9 сонсгол зохион байгуулаад байна. Хянан шалгах түр хороод байгуулагдаад хуульд заасан тусгай шалгалтыг явуулж байгаагаас 2 түр хороо нотлох баримтыг шинжлэх, судлах сонсголыг хийж тайлангаа тавиад, татан буугдсан байгаа. Ингэснээр нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар Үндсэн хуульд заасан иргэдийн мэдэх эрхийг хангаж ажиллаж байгаагийн зэрэгцээ сонсголоор илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох чиглэлээр ЗГ-т үүрэг чиглэл өгч ажиллаж байгаа.

Ер нь энэ хяналт шалгалтын ажил, түүний эрх зүйн зохицуулалт бол энийг сайжруулах шинэчлэх болбол өөрөө тасралтгүй үргэлжлэх үйл явц. Урьд өмнөх зүйлүүдтэйгээ харьцуулаад илүү боловсронгуй асуудал болбол байнга боловсронгуй болж байх ийм шаардлага зүй ёсоор гарч байгаа. Улсын Их Хурлын Монгол Улсын хэмжээнд хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн хэрэгжилт, үр нөлөө хангалтгүй байна. Тийм учраас хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр ЗГ-ын үйл ажиллагаанд тавих Улсын Их Хурлын хяналтыг цаашид илүү чанга болгох, боловсронгуй болгох ийм шаардлага, эрх зүйн орчныг нь боловсронгуй болгох шаардлагууд байгаа. Эдгээр зүйлүүдийг харгалзаж үзээд Хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулсан 8 бүлэг нь, 58 зүйлтэй.

Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл бол 21 онд баталсан хуулийнхаа үзэл баримтлалыг хэвээр хадгалсан. Энэ

удаагийн эрх зүйн шинэчлэлийн зорилго нь Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн үзэл саналд тулгуурлаад Их Хурлын 19-өөс 24 оны стратеги зорилтын хүрээнд дэвшүүлсэн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг гүнзгийрүүлэх, ханган биелүүлэхэд нь тавих хяналтыг сайжруулахад чиглэгдэж байгаа гэж үзэж болно. Хууль тогтоомжийн биелэлтийг хангавал төсвийн хяналтыг өргөжүүлэх, Улсын Их Хурлын гишүүн асуулт асуулга тавих, Ерөнхий сайдын мэдээлэл сонсох ажиллагааг боловсронгуй болгох, үр нөлөөг дээшлүүлэх, Хянан шалгах түр хорооны эрх зүйн зохицуулалтыг сайжруулах зэрэг хууль хэрэгжүүлэх шатад тулгамдаж ирсэн энэ шинэ хууль хэрэгжиж эхэлснээс хойш энэ хугацаанд тулгамдаж ирсэн асуудлуудыг шийдвэрлэх чиглэлээр эрх зүйн орчныг нь сайжруулах асуудлыг энэ төсөлд тусгахыг зорьсон.

Энэ дотор гишүүдийн тоо нэмэгдсэнтэй холбоотой ерөнхий хяналтын, хүний эрхийн, төсвийн, нэр дэвшигчийн сонсгол явуулах хүсэлт гаргах гишүүдийн тоог 15 байхаар, Түр хорооны бүрэлдэхүүнийг 7-гоос 31 хүртэлх хүний, гишүүдтэй байхаар өөрчилсөн. Ингэхдээ нийт гишүүдэд эзлэх хувь хэмжээтэй жишиг энэ тоог өөрчилнө. Хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах ЗГ, Улсын Их Хуралд ажлаа шууд тайлагнадаг байгууллагуудад тавих хяналтыг сайжруулах, хууль тогтоолоор үүрэг чиглэл өгсөн Их Хурлын шийдвэрийн биелэлтийг тогтмол сонсож хэлэлцдэг болно. Энд асуудал болгоноор урьд нь ерөнхийдөө тайлагна гээд орхидог байсан болбол одоо сонсдог хэлэлцдэг болно гэсэн заалтууд нэлээн их орсон байгаа. Их Хурлаас хийх үр дагаврын үнэлгээний тайланг оновчтой хэлэлцэх, ЗГ-ын нийтээр дагаж мөрдөх эрх зүйн актын шаардлагатай уялдуулаад хянаж үзэх, хүчингүй болгох, хариуцлага тооцох зэрэг өөрчлөлтүүдийг тусгаж байгаа. Хяналт шалгалтын ажлын хэсгийн үйл ажиллагааг чанаржуулах, үр нөлөөг нь

нэмэгдүүлэхтэй холбоотой ажлын хэсэг байгуулахад тавигддаг шаардлагыг нэмэгдүүлж байна. Ажлын хэсгийн явц байдал, үр дүнг холбогдох Байнгын хороо сонсоод, ажлын үр дүнг харгалзан ажлын хэсгийг татан буулгах эсхүл үргэлжлүүлэн ажиллуулах эсэхийг шийдвэрлэдэг болохоор зохицуулалт оруулж байна.

Их Хурлын хяналт шалгалтын төлөвлөлтийг бодитой болгох, биелэлтийг нь хангуулах, хүчин чадлыг нэмэгдүүлээд Улсын Их Хурлын хяналт шалгалтын цаглаврыг Улсын Их Хурал өөрөө Их хурлын тогтоолоор баталж байхаар санал оруулж байгаа. Ерөнхий сайдын 14 хоног тутамд мэдээлэл хийх зохицуулалтыг сард нэг удаа болгоод, бодлогын шинжтэй асуудлаар хэлэлцүүлэг явуулах, мэдээллийн цагийн үргэлжлэх хугацааг 1 цаг 30 минутад багтаах, хариулагдаагүй асуултуудыг бичгээр авч, цахим системд байршуулах байдлаар мэдээллийн хэлэлцүүлгийн чанар, үр нөлөөг нэмэгдүүлэх, нийгмийн зүгээс тавих хяналтыг сайжруулах зохицуулалтыг оруулж байна.

Улсын Их Хурлын гишүүний асуулт, асуулга түүний хариуг Байнгын хороонд танилцуулж хэлэлцүүлдэг болно. Улсын Их Хурлын төсвийн хяналт шалгалтыг өргөжүүлж, төсвийн боловсруулалтын үе шатад тавих хяналтыг бий болгоно. Одоо бол үндсэндээ ЗГ боловсруулчхаад, оруулж ирсэн хойно төсвөө ярьж байгаа. Цаашидаа болбол ЗГ боловсруулж байх явцад нь бас төсвийн хяналтад, төсвийн боловсруулалтад хяналт тавих ийм тогтолцоог бий болгох нь зүйтэй гэж үзэж байгаа.

Энэ Их Хурлаас зохион байгуулах хянан шалгах үйл ажиллагаанд иргэний нийгмийн болон төрийн хяналт шалгалтын байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх, тэдний хамтын ажиллагааны уялдааг сайжруулахад чиглэсэн зарим өөрчлөлтүүдийг тухайлбал Төрийн аудитын байгууллага,

Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанк, Хүний эрхийн Үндэсний Комисс зэрэг байгууллагууд Байнгын хорооны даалгаснаар Улсын Их Хурлын хяналт шалгалтыг явуулж байхаар байж болох. Мөн Их Хурлаас төрийн байгууллагын тайлан, илтгэл хэлэлцэх хууль тогтоомжийн үр дагаврын үнэлгээ хийхдээ хөндлөнгийн хараат бус байгууллага, мэргэжсэн судлаачдаар дүн шинжилгээ хийж, оролцоог нь нэмэгдүүлж байх талаар. Хянан шалгах түр хорооны эрх зүйн зохицуулалтыг сайжруулж, хууль хэрэгжүүлэх шатад тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэнэ. Энд үүнд болбол Түр хороог байгуулах, татан буулгах асуудлыг Их Хурлын тухай хуульд зааснаар Түр хорооны гишүүдийн ашиг сонирхлын зөрчилгүй байх шаардлага, Түр хорооны даргын эрх, үүргийг тодотгож заасан. Ямар тохиолдолд ямар Түр хороонд ажиллаж болох вэ, болохгүй гэдгийг нь бас ашиг сонирхлын зөрчлийн байдалтай нь уялдуулаад харгалзаж үзэж байхаар.

Хянан шалгагч шинжээч нарын эрх зүйн байдлыг илүү тодорхой болгох, тэдэнд тавигдах шаардлагыг нэмэгдүүлэх. Мөн ашиг сонирхлын зөрчилгүй байдал талаарх мэдэгдлийг нь болон нууц хадгалах баталгаа зэрэг зүйлүүдийг заавал гаргаж байхаар өөрчлөлтүүд тусгасан. Гэрч дуудах зохицуулалтуудыг сайжруулахаар бодож оруулсан. Гэрчийн нэрсийг гаргах, танилцуулах хугацааг тодорхойлоод, мэдэгдэх хуудсыг нь хүргүүлэх хэлбэр, хүндэтгэн үзэх шалтгаануудыг илүү тодорхой болгож зарласан байгаа. Энэ төсөлтэй энэ хуулийн төсөлтэйгөө хамт Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нийтийн сонсголын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Олон нийтийн радио, телевизийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг хамт боловсруулж, өргөн мэдүүлсэн. Ингэж энэ хуулийн

төслүүдийг баталснаар Үндсэн хуулийн хүрээнд Улсын Их Хурлын хяналт шалгалтын эрх зүйн шинэчлэлийг гүнзгийрүүлэхэд тодорхой хувь нэмэр оруулна гэж хууль санаачлагч үзэж байгаа.

Дахиад давтаад хэлэхэд энэ бол байнга боловсронгуй болгож, зөвхөн нэг энэ удаагийн хуулиар биш цаашидаа ч гэсэн ажлын явц, үр дүн юмнуудыг нь харгалзаж байгаад байнга боловсронгуй болгож байх хууль юм билээ. Энэ хууль хэчнээн сайн гарч, хэр сайн хэрэгжсэнээр Монгол Улсын Их Хурал ялангуяа ЗГ-ын үйл ажиллагаанд хяналт тавих, хэрэгжилтийг нь хангуулах тал дээр илүү их нөлөө бүхий хэрэгсэлтэй болно гэж ингэж үзэж байгаа. Та бүхнийг хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд нь хэлэлцэхийг, асуудлыг шийдвэрлэж өгөхийг хүсье.

Хууль санаачлагчийн илтгэлтэй холбогдуулаад асуух гишүүн байвал нэрээ өгье. Сарангэрэл, Ганболд. Сарангэрэл гишүүн. Манай ажлын хэсгийнхэн бас байгаа. Тодруулах зүйл, тодорхой зүйлд нэмж хариулж болно. Сарангэрэл гишүүний микрофон.

**Д.Сарангэрэл:** Баярлалаа. Товчхон асуулт тавиад орхиё. 2019 оны Үндсэн хуулийн өөрчлөлтийн хүрээнд бид нар Улсын Их Хурлын хяналт шалгалтын анхдагч хуультай болсон. Энэ хуулийн ач холбогдол бий, бий. Төсвийн, томилгооны, нэр дэвшигчийн гээд ингээд сонсголууд хийдэг болсон. Тэгэхдээ Их Хурлын гишүүдийн бас нөхцөл байдлыг харж байхад илүүтэй энэ хуулийн төсөл дээр нөгөө ерөнхий хяналтын сонсголын тал руугаа их ач холбогдол өгч, бараг л ер нь тэрний хууль юм шиг ийм байдлаар асуудалд хандаад байгаа зүйл гарч байгаа юм.

Тэгээд Энхболд дарга сая хэллээ. Их Хурлын энэ хяналт шалгалтын тухай хуулийг байнга амьдралд нийцүүлж хөгжүүлж, боловсронгуй болгож, өөрчлөлт оруулж байх ёстой хуулийн

төсөл юм билээ гэж би бүрэн дүүрэн санал нэг байна. Тухайлбал парламент бол хууль тогтооно. Тэр тогтоосон хуулийг хэрэгжүүлдэг газар нь ЗГ. Тэгэхээр өнөөдөр Монгол Улсад үйлчилж байгаа 800 гаруй хуулийн хэрэгжилт ямар байгаа юм бэ? ЗГ-нийг тодорхой хугацаанд бид нарт тайлан тавьж байгаа юу, тайлантай холбоотой бид нар дүгнэлт хийгээд, хэрэгжилт нь муу байгаа бол хэрэгжилтийг нь сайжруулах талаар юу хийж байгаа вэ гээд өнөөдөр эргээд харахаар тэр зүйл нь үнэхээр хангалтгүй байгаад байгаа юм. Тэгэхээр тэр ерөнхий хяналтын сонсголын тухайн нэг асуудал гарсан хойно нь нийгмийг бужигнуулаад, өөрснөө ч бужигнаад нэг тийм ерөнхий хяналтын сонсгол хийхээсээ илүүтэй, хэрэв бид нар энэ Хяналт шалгалтынхаа тухай хуулийг тогтвортой байнгын үйл ажиллагаатай байдлаар явуулах юм бол заавал энэ ерөнхий хяналтын сонсгол руу орохгүй байх тийм боломж бол би бүрдэнэ гэж ингэж үзэж байгаа юм.

Тухайлбал Улсын Их Хурлын гишүүд асуулт тавьж байна, асуулга явуулж байна. 3 парламентад суугаад харж байхад ямар ч үр дүн байдаггүй. Асуулга тавилаа тухайн яам нь нэг мэдээлэл бэлтгээд, тэрийг Их Хурлын гишүүд нэг сонссон болоод, зарим нь нэг үг хэлээд ингээд өнгөрч байгаа юм. Тэгээд тэнд яригдсан зүйлүүд хугацаатай үүрэг чиглэл өгөх, эргээд түүнийг нь тайланг сонсох тухай асуудал ерөөсөө байхгүй. Тэгэхээр энэ Хяналт шалгалтын тухай хуульд үүнийг заавал оруулах шаардлагатай. Асуулга тавьсан бол ямар хугацааны дараа эргээд тэрнийхээ тайланг сонсох вэ? Хэрвээ тэр чиглэлээр үйл ажиллагаа явуулаагүй бол хэнд ямар хариуцлага тооцох вэ гэдэг нь тодорхой байх ёстой. Тэгэх юм бол гүйцэтгэх засаглалын болон энэ гүйцэтгэх засаглалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа төрийн яамд, агентлагийн үйл ажиллагаа, тэнд ажиллаж байгаа хүмүүсийн хариуцлага эрс сайжрах ёстой.



Ерөөсөө Их Хурал дээр яригдаж байгаа зүйлүүд ярилаа, сонслоо, шуугиуллаа, хавтсанд орлоо, дууслаа. Энэ хуулиар бид нар ийм л өөрчлөлтийг хийх ёстой гэдгийг л би та бүхэндээ хамгийн түрүүнд хэлэх гээд байгаа юм. Мэдээж хэрэг тэр ерөнхий хяналтын сонсгол явуулах юм бол 15 гишүүн санал гаргах юм байна, бүрэлдэхүүнд нь 7-гоос 31 гишүүн орох юм байна. Энэ бүхэн бол хэрэгтэй. Тэгэхдээ энэ асуудлууд дандаа хууль зөрчөөд болохоо байгаад, нийгмийг шуугиулаад тэгээд бид нарыг эргээд ард иргэд шахахаар зэрэг л хийж байгаа ажлууд шүү дээ. Бид нар өөрснөө бүгдийг нь мэдэж байгаа. Тэгээд хэрэв бид нар энэ Хяналт шалгалтынхаа тухай хуулийг дахин давтан хэлэхэд Их Хурал ЗГ-ын хууль хэрэгжих үйл ажиллагааг жинхэнэ утгаар нь, жинхэнэ утгаар нь хянаж чадаад, тайланг нь аваад, хуулийн хэрэгжилтээ тогтвортой, тогтвортой цаг хугацаанд хянаад явах юм бол ийм зүйл үүсэхгүй байх боломжтой. Миний хэлэх гэж байгаа гол санаа тэр механизмуудыг энэ хуулийн төсөлд суулгаж өгөх ёстой гэдгийг л хэлэх гээд байгаа юм. Баярлалаа.

**Н.Энхболд:** Бараг санал хэлчихлээ. Гэхдээ би юу яачихъя, энэ тийм, энэ дээр яг тэр заалт дээр Үнэнбат дарга хэлчхээрэй, яг хариуцлагын тухай асуудлыг. Би бол ерөнхий 2 зүйлийг нь хэлчихье. Ер нь зүгээр асуудал үүсчихсэн хойно биш, ерөөсөө хууль тогтоомжийн хэрэгжилт болж байна уу, үгүй юү гэдгийг бид нар өөрснөө төлөвлөгөө гараад бүүр зориуд цаглавартай болгоод, тэр цаглаварынхаа дагуу хийж байя гээд энэ дээр заалт орчихсон байж байгаа. Одоо тийм заалт байхгүй. Тэгэхдээ хуульд бүүр одоо нэг юм бий л дээ. Тэгээд заавал нэг их хэрэгжээд байхгүй ч юм шиг тийм болно шахуу биччихсэн. Одоо болбол заавал хийнэ, цаглавраа батална, тийм. Тэгээд, тийм. 10 дугаар зүйл дээрээ товчхон тайлбар хэлчхээрэй Үнэнбатаа.

Энэ өнөөдрийн бид нарын хэлэлцээж байгаа 3 хууль чинь 3-уулаа

Сарангэрэл гишүүнээ 3-уулаа Их Хурлын тухай хууль, Хяналт шалгалтын хууль, Дэгийн тухай хууль чинь 3 хоорондоо тодорхой хэмжээгээр уялдаатай хуулиуд шүү дээ тийм ээ. Хамгийн чухал нэг зүйл орсон нь би Их Хурлын хууль дээр жишээ нь өнөөдөр ингээд Ерөнхий сайд сайдыг томилоод хариуцлагыг нь өөрөө хүлээгээд явж байгаа. Гишүүд сайд нартай хариуцлага тооцох боломж байхгүй байгаа. Гэтэл тухайн салбарт асуудал гараад байдаг, тэрийг яаж шийдэх вэ гэдэг дээр бол хэрэглэх механизм байхгүй болсон. Их Хурлын хуульд бид нар жишээ нь Байнгын хорооны гишүүдийн 2/3 нь ийм сонсголын мөрөөр ч юм уу эсхүл өөр ямар нэгэн байдлаар тухайн салбарын сайд ажлаа хийж чадахгүй байна гэж үзвэл тэр хүнийг огцуулах тухай асуудлыг, итгэл үл үзүүлэх тухай асуудлыг тавьж байх ийм боломжийг нээсэн. Энэ өөрөө их том алхам. Энэтэй яг уялдана.

Сонсгол хийлээ, энэ чинь болохгүй байна, тэр чинь болохгүй байна шалгалаа, үүрэг өглөө, биелүүлэхгүй байвал тэгээд орхичихдог байсан бол одоо бид нар тэгвэл Байнгын хороондоо ярьж байгаад энэ хүн чинь сонсголын мөрөөр ямар ч арга хэмжээ авахгүй байна. Байдал хэвээрээ байна, хариу өгөхгүй байна. Энэтэйгээ хариуцлага тооцоо гэдэг асуудлыг Их Хурлын гишүүд Байнгын хороодын хариуцсан Байнгын хороодын гишүүн 2/3-оор тавьдаг энэ юу болбол нэлээн том Үндсэн хууль зөрчөөгүй, Ерөнхий сайдын бүрэн эрхэд халдаагүй. Гэхдээ энэний дагуу арга хэмжээ авч явахгүй бол ерөөсөө болохгүй ийм л зохицуулалт оруулж байгаа. Тэгэхээр энэ бүгдээрээ хоорондоо уялдаатай. Саяын таны хэлсэн юмны нэг асуулт, нэг тэнд нэг тийм том хэрэгсэл орсон байгаа шүү гэдгийг бас хэлчихье. Яг сонсголын мөрөөр тодорхой арга хэмжээ авахгүй болбол яах ёстой вэ гэдэг 10 дугаар зүйл дээр байх ёстой доо. Тийм тэрийгээ хариуцлагын тухай.

**М.Үнэнбат:** Гишүүдийнхээ энэ өдрийн мэндийг хүргэе. Сарангэрэл



гишүүний асуултад хариулъя. Ер нь бол асуулга, асуулттай холбоотой зохицуулалт бол өмнө нь өнөөдрийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуультайгаа тэр зохицуулалт бол хэвээр үргэлжилж байгаа. Энэ дээр зүгээр нэг зүйлийг хэлэхэд саяын таны хэлснээр Улсын Их Хурлын тогтоол болон Байнгын хороод өөрийн эрхлэх асуудлын хүрээнд харьяа ЗГ-ын байгууллагууд, ЗГ, мөн Улсын Их Хуралд ажлаа тайлагнадаг байгууллагуудын чиглэлээр үүрэг чиглэл өгсөн тогтоол гаргадаг. Тэр тогтоолын биелэлт хэрэгжилт ямархуу түвшинд байна вэ гэдгийг өнгөрсөн хугацаанд харахаар бол зарим заримдаа бол хангалтгүй асуудал гардаг.

Тэгэхээр энэ дээр шийдвэрлэх зорилгоор бид нар 3 зүйл оруулж өгч байгаа. 1-д 9 дүгээр зүйл, 10 дугаар зүйл, 16 дугаар зүйл гэсэн ийм 3 зүйл гаргаж байгаа. Тэгээд тэр нь юу байна вэ гэхээр тухайн үүрэг чиглэл өгсөн тогтоолын биелэлт нь ямар байгаа юм гэдгийг ээлжит чуулган эхлэхээс 15-аас доошгүй хоногийн өмнө ЗГ заавал тайлангаа ирүүлдэг. Тэр ирүүлсэн тайлан дээр нь манай Тамгын газрын Дун шинжилгээний хэлтсийнхэн дүгнэлт хийгээд, холбогдох Байнгын хороонд нь хүргүүлдэг. Тэгээд Байнгын хороо тэр асуудлыг авч хэлэлцээд яг өгсөн үүрэг даалгавар чиглэл нь нөгөө бүрэн гүйцэд биелээгүй тохиолдолд хянан шалгалтын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээ гээд холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох хүртэл санал гаргах ийм боломжийг нь бол хуулиар нээчихсэн байж байгаа.

Сая тэгээд мөн Энхболд даргын хэлснээр болбол бүлгүүд өөрсдөө тухайн ЗГ-ын гишүүнтэй ямар нэгэн алдаа дутагдалтай ЗГ-ын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр хангалтгүй биелжээ гэдэг ч юм уу ийм асуудал гарсан тохиолдолд бүлэг дээр яриад, бүлэг санал гаргах юм бол холбогдох Байнгын хороонд нь саналаа тавьдаг. Тэр саналыг нь холбогдох Байнгын хороо хэлэлцээд, нийт гишүүний 2/3-оор нь дэмжих юм

болбол Ерөнхий сайдад тухайн ЗГ-ын гишүүнд хариуцлага тооцох саналаа хүргүүлдэг ийм зохицуулалт явж байгаа.

Асуулгын тухайд болбол одоогийн өнөөдрийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулиар асуулгыг бол ирэнгүүт нь гишүүний саналыг үндэслээд чуулганаар оруулдаг ийм зохицуулалт байгаа. Энэ дээр бол орж байгаа ганц өөрчлөлт юу байна вэ гэхээр асуулга болгоныг тухайн Байнгын эрхлэх асуудлыг хариуцсан Байнгын хороо хэлэлцдэг, тэгээд хэлэлцээд тухайн асуудлыг нь чуулган руу оруулж шийдвэрлэх үү гэдэг санал, дүгнэлт гардаг. Тэгээд ороод тэр асуулгатай холбоотойгоор мөн асуулга бол хяналт шалгалтын нэг хэлбэр. Тэгээд энэ асуудалтай холбоотойгоор мөн асуулга тавьсан асуудал нь хангалтгүй байна гэж үзэх юм болбол тухайн Байнгын хороо дахиад л хариуцлага тооцох асуудал нь бол нээлттэй, тэр зохицуулалтыг бид нар бол оруулчхаад байж байгаа.

**Н.Энхболд:** Би ганицхан зүйл нэмээд хэлчихье, Сарангэрэл гишүүнээ. Энэ жишээ нь сонсгол хийгээд ЗГ-т буруу, зөв шийдвэрүүдээ засах, хуульд нийцүүлэхийг үүрэг болгоод чиглэл өгчихнө, тогтоол баталчихна тийм ээ. Тэгээд тэр тогтоолоо бол хэлэлцээд, хэрэв тэр тогтоол хэрэгжүүлээгүй байвал Үндсэн хуульд, Үндсэн хуульд байгаа эрхийнхээ дагуу Засгийн юу, Улсын Их Хурал ЗГ-ын тэр тогтоолыг нь бүүр хүчингүй болгох хүртэл эрхтэй л дээ. Тэгээд тэр бол хуучин хуульд байгаагүй, шинэ төсөл дотор бол бид нар жишээ нь 10.6 дээр Улсын Их Хурал түрүүн гаргаад нөгөө үүрэг өгсөн тогтоолынхоо биелэлтийг 10.5-д заасны дагуу хэлэлцээд, хуульд нийцүүлж ЗГ-ын зүгээс тэр шийдвэрийг хуульд нийцүүлэх арга хэмжээг бол Үндсэн хуулийн 45.2-т заасны дагуу шийдвэрийг нь хүчингүй болгоно гээд бүүр энэ хуульд зориуд нэмээд оруулчхаж байгаа юм. Тэгэхээр сайдынхаа асуудлыг ярих уу, ЗГ-ынхаа шийдвэрийг хүчингүй болгуулах уу гэдэг дээр бас ЗГ заавал юм бодох хэрэгтэй

болно л гэж ойлгож байгаа. Тэгэхээр энэ бол нэг бас энэ хуульд шинээр зориуд шинээр оруулсан заалт шүү гэдгийг бас хэлмээр байна. Ганболд гишүүн.

**Г.Ганболд:** Нэгэнт уг нь хэдүүлээ энэ шинэчилсэн найруулгаар оруулж байгаа болбол энэ хэдэн сонсголууд дээрээ нэлээн томхон өөрчлөлт л хийчихмээр байгаа юм даа. Жишээлбэл томилгооны сонсгол дээр энэ гаднын улс орнууд чинь хэрэглэсээр байгаад туршилага нь ирчихсэн байна. Энэ ёс зүй энэ тэрийг нь болбол хаалттай хэлэлцдэгээр ингээд шууд оруулчихмаар байх юм. Тэр мэргэжил, ур чадварыг нь болбол нээлттэй сонсгол явуулна биз. Хувь хүний амьдрал ахуйтай, ёс зүйтэй холбоотой асуудлуудыг нь болбол хаалттай хийдэг ийм юмаа энд нэг мөсөн оруулчихмаар байх юм.

Ерөнхий хяналтын сонсгол дээр энэ 29.2.4-д байгаа энэ эрх ашиг нь хөндөгдсөн иргэн гэдгийг авчхаад, ер нь бол хяналтын ерөнхий сонсгол ер нь жаахан улс орны эрх ашиг хөндөгдсөн юмнууд дээр хийдэг баймаар юм шиг байгаа юм. Өмнө нь бас нэг бөөн ерөнхий хяналтын сонсгол гээд энэ заалаар дүүрэн амьтан орилоод л нэг дампуурсан юм болсон шүү дээ. Энийг болбол бас нэг жаахан цэгцлэх хэрэгтэй юм шиг байгаа юм.

Тэгээд энэ түр хорооны энэ Хянан шалгах түр хороон дээр болбол бас нэлээн олон асуудлууд байгаа юм. Одоо энэ дээр энэ шинжээч, хянан шалгагчдын эрхийг нэг жаахан тодорхой болгож өгөөд, ямар хүн шинжээч, хянан шалгагчаар томилохыг бас тодорхой заахгүй болбол бас их төвөгтэй байдал үүсэх юм байна лээ. Гадуур бас зүгээр хайж байгаад л хэнийг хамаагүй авдаг, шалгуур юу ч байхгүй. Шинжээч, хянан шалгагч нарт. Тэгээд шалгуургүй учраас тэтгэвэрт гарсан хүмүүс л олдох юм байна лээ ер нь бол. Ажил төрөлтэй хүмүүс олдоно гэж байхгүй. Тэгээд энэ шинжээчдийн дараа нь гаргасан дүгнэлтдээ хариуцлага хүлээдэг юмтай

байхгүй бол хэнийг хамаагүй юу, хамаагүй дүгнэлт бичиж ирж байгаа байхгүй юу. Тэгэхээр зэрэг энэ шинжээч, хянан шалгагчдыг болбол бас шалгууртай, тэгээд дараа нь өөрсдөө тэрэндээ хариуцлага хүлээхгүй бол яг саяын тэр нүүрс дээр болбол шинжээчид бол маш хариуцлагагүй дүгнэлт хийсэн хүмүүс зөндөө байгаа шүү дээ. Сүүлд нь нөгөөдүүл нь нотлох баримтаар тогтоогдоод.

Тэгээд нөгөө талаас энэ Түр хороон дээр дуудагдаж ирж байгаа хүмүүст яг ямар асуудлаар дуудаж байгааг нь бүүр тов тодорхой бичиж өгөөд, тэр хүн чинь өөрөө хувийн зүгээс нотлох баримтаа барьж ирэх ёстой байхгүй юу. Тэгэхгүй бол нэг тал нь хэт мэдээллийн давуу байдал ингээд юмаа олчихсон, тэгээд нөгөөдүүл нь юунд дуудагдаж байгаагаа мэдэхгүй ирээд ингээд л асуудал үүсээд байгаа. Уг нь 2 талаасаа ингээд нотлох баримтаа тулгаад яг бодитойгоор яг хэн нь үнэн зөвөө ингэж олж явдаг баймаар.

Тэгээд энэ Түр хороон дээр энэ хамгийн гол юм бол төрийнхөн, төрийнхнөөс бол бид нар ингээд материалуудыг бол олоод авчих юм байна лээ. Хувийнхан гол шалгах гэж байгаа субъект бол ихэвчлэн хувийнхан байдаг нөгөө талдаа төртэй гэрээ хийсэн. Хувийнхан ерөөсөө нөгөө материал гаргаж өгдөггүй. Энэ Чинбүрэн эмч үглээд л яваад байна, нэг эм дээр ерөөсөө материал гаргаж өгөхгүй байна гээд л. Тэгээд тэр тохиолдолд энэ хувийнхны нөгөө үүрэг хариуцлагыг нь жаахан нэмэгдүүлж, тодорхой болгож явах л шаардлагатай юм байна лээ дээ. Маш олон асуудлуудыг энэ дээр тодорхой болгохгүй бол одоо ингээд л тэр Түр хороог тухайн сэдвээс нь хамаараад л цөөнхийн хүнээр даргыг томилж болно гэхчсэн. Сэдвээс хамаараад. Тэгээд ямар сэдэв байвал цөөнх нь даргалах юм. Үгүй ээ үгүй харин тийм л дээ. Тэгээд энэ чинь олонх нь яг ямар сэдэв байвал олонх нь даргалж болох юм, ямар сэдэв байх юм болбол

цөөнх нь даргалах юм гэдгийг ингээд тодорхой болгохгүй бол ингээд дандаа л ойлгомжгүй юмнууд л яваад байгаа юм л даа. Тэгэхээр энэ дээр нэг тийм жаахан нэлээн томоохон өөрчлөлтүүд л гурвуулан дээр нь хийчихмээр л байгаа юм даа.

**Н.Энхболд:** 1 дүгээрт хаалттай хэлэлцэхийн хувьд бол ийм заалт байгаа Ганболд гишүүнээ. 30.2 дээр нэр дэвшигчийн хувь хүний нууцад хамаарах мэдээллийг хаалттай хэлэлцэнэ гээд тийм, 30.2 дээр заачихсан байж байгаа. 2 дугаарт, тийм тэр тэгээд тэр ёс зүй, нөгөө хувь хүнтэй холбоотой юмнууд нь бол хаалттай хэлэлцэнэ гээд ингээд заачихсан.

Шинжээч, хянан шалгагч нарт тавих энэ асуудлыг 40 дүгээр зүйл дээр шинжээч томилно гээд байгаа. Энэ дээр яах вэ бүүр тодруулаад ийм, ийм юм оруулах хэрэгтэй байна гэвэл хүлээж авахад хууль санаачлагчдын зүгээс бэлэн байгаа. Бэлэн байгаа, энэ дээр та бас ажлын хэсэгт бодвол энийг хэлэлцэх эсэхийг шийдчихвэл ажлын хэсэг гараад ажиллах байх. Тэрэн дээр саналаа өгч болно шүү.

Тэгээд хариуцлага хүлээхийн хувьд бол бас 57.5 дээр шинжээч тогтоосон хугацаанд дүгнэлт гаргаж өгөөгүй эсхүл зайлсхийсэн, мэдүүлэг өгөхөөс зайлсхийсэн, татгалзсан гэх мэтчилэн ийм зүйлүүд гаргасан бол энийг Зөрчлийн тухай хуулиар хариуцлага хүлээлгэнэ. Зориуд худлаа дүгнэлт гаргасан бол Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ гэж заалтууд орсон байгаа шүү. 57.5, 6 хоёрыг та нэг харчхаарай тийм. Ийм зүйлүүд.

Нотлох баримт гаргаж өгөхийн хувьд болбол хүн, хуулийн этгээдээс нотлох баримт гаргаж өгөх заалтууд 43 дугаар зүйлд орсон байгаа. Харин тэгвэл яавал заавал гаргаж өгдөг болох вэ гэдэг дээр та жишээ нь Түр хорооны даргаар ажилласан хүн зовлонг нь мэдэж байгаа, бас тодорхой саналууд байвал ажлын

хэсэгт яг ингээж томъёолоод оруулчихвал өгмөөр юм шиг байна лээ гээд өгчихвэл хууль санаачлагчийн хувьд бид нарт хүлээж авахад бэлэн байгаа. Тийм.

Үг хэлэх хүн байна уу? Алга байна. Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. Ингээд Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд нь хэлэлцэх нь зүйтэй гэсэн томъёолоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 11 гишүүн оролцож, 7 дэмжиж, 63,6 хувиар үзэл баримтлалын хүрээнд дээрх хуулиудын төслийг хэлэлцэх нь зүйтэй гэж үзлээ. Санал дүгнэлтийг Ганболд гишүүн чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулна.

11.54 цаг

Нэг асуудал байгаа. Одоо хэрэв чуулганы хуралдаанаар Байнгын хорооноос оруулсан саналыг дэмжээд, 3 хуулийг хамт өргөн мэдүүлсэн хуулиудынх нь хамт өргөн юу, хэлэлцэх нь зүйтэй гээд дэмжчихвэл бид нар ажлын хэсэг байгуулаад ажиллана. Ажлын хэсгийн шийдвэрийг би Их Хурлын даргаар гаргуулчих нь зүйтэй болов уу гэж бодож байна. Бас санал солилцсон.

Яагаад гэвэл дахиад ажлын хэсгээ ярина гэвэл бид дахиж хуралдах хэрэг гарна. Бүлгээс төлөөлөл буюу 2 бүлгээс төлөөллүүд, ХҮН намын төлөөлөлтэй ярьж байгаад орно гэвэл өөрсдийг нь оруулаад ингээд 5, 6 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулна. Нэрсээ болбол ерөнхийдөө ярьчихсан байгаа. Тогтохсүрэн гишүүнийг ажиллаад, ахлаад ажиллах нь зөв болов уу гэж бодож байгаа. Тэгэхээр манай одоо Байнгын хорооны ажлын алба юу ч гэсэн даргын Их Хурлын даргын захирамж бэлдээд, өгсөн нэрснүүдийг оруулаад надад өгөөдөх.





